Хавсралт

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

## (2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнав)

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)

2023-07-05 Улаанбаатар хот

| **Шийд-вэр-ийн д/д** | **Зүйл, заал-тын д/д** | **Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалтын дугаар, агуулга** | **Биелэлт** | **Үнэлгээ,** (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | **Тасарсан болон удааширч байгаа шалтгаан** |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** |
| **Нэг. Монгол Улсын хууль** | | | | | |
| 1 | 1 | **Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/**<br>2017-12-07, Хэрэгжиж эхлэх: 2019.01.01<br>55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/36 дугаар тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг батлав. Уг хөтөлбөрийг дараах 4 үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Байгууллагын хүний нөөцийн чадамжийг бүрдүүлж, үйл ажиллагааны тасралтгүй чанарыг хангана;<br>– Төрийн албан хаагчийн ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулна;<br>– Төрийн албан хаагчдын цалин хөлс, урамшуулал, амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлнэ;<br>– Төрийн албан хаагчдын биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн байдалд анхаарна.<br>Хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг 2023 оны эхний хагас жилийн хүрээнд хэрэгжүүлэв.<br>Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсантай холбогдуулан үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлэн тооцож олгох | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | асуудлыг ТӨБЗГ-ын даргын 2023 оны Б/10 дугаар тушаалаар шийдвэрлэж, 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна. Мөн ТӨБЗГ нь төрийн үйлчилгээний нийт 11 ажилтантай бөгөөд тэдгээрт үндсэн цалингаас ур чадварын, төрийн алба хаасан хугацааны болон бусад нэмэгдлүүдийг олгож байна. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд нийт албан хаагчдад олгох хоол, унааны зардлыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ТӨБЗГ-ын даргын А/37 дугаар тушаалаар 12,000 төгрөг болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.<br><br>Эхний хагас жилийн байдлаар албан хаагчдад холбогдох тусламж, дэмжлэгийг хууль тогтоомжийн дагуу олгов. Тухайлбал, Цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан байгууллагын ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэн 27 ахмад настанд тус бүр 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Ар гэрийн шалтгаанаар чөлөө авсан болон гачигдал тохиолдсон 5 албан хаагчид цалинтай чөлөө олгож, тусламж олгов.<br><br>ТӨБЗГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/17 дугаар тушаалаар 2023 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Сургалтын төлөвлөгөөний дагуу 2023 оны эхний хагас жилийн байдлаар дараах сургалтуудад албан хаагчид хамрагдаад байна. Үүнд: мэргэшүүлэх сургалтад 10, ажлын байранд зохион байгуулагдсан 4 төрлийн сургалтад давхардсан тоогоор 120 албан хаагчдыг хамруулав. Албан хаагчдын англи хэлний түвшинг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулсны үндсэн дээр гадаад хэлний "Абсолют сургалтын төв"-тэй хийгдсэн гэрээний дагуу англи хэлний сургалтад 9 албан хаагч суралцаж төгссөн байна. | | |
| 2 | 2 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны https://pcsp.gov.mn цахим хуудсанд байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг байршуулсан. Холбоос: https://pcsp.gov.mn/?page_id=4538. Тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тус албан ёсны цахим хуудасны бусад цэс дэх мэдээллээр илэрхийлэгдэнэ. Тухайлбал, холбогдох мэдээ, мэдээлэл, арга хэмжээ, төлөвлөгөө, тайлан зэрэг болно. | "Бүрэн хэрэгжсэн" - 100% | |
| | 3 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаягуудыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны https://pcsp.gov.mn цахим хуудсанд холбогдох | "Бүрэн хэрэгжсэн" - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | буланг нээж байршуулсан. Нийгмийн цахим сүлжээний https://www.facebook.com/pcsp.gov.mn фэйсбуук пэйж хуудсыг тогтмол хөтлөн цаг үеийн мэдээллийг байршуулан мэдээлж байна. | | |
| | 4 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Энэ хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, тайлант хугацаанд байгууллагын албан ёсны цахим хуудсыг хөгжүүлэх, хуульд нийцүүлэх, мэдээллийн шинэчлэл хийхэд анхаарав. Хуулийн энэхүү заалтад дурдсан мэдээллийг нээлттэй байршуулах боломжийг цахим системд бий болгон холбогдох мэдээллийг байршуулан мэдээлж байна.<br>Үйл ажиллагаа, түүний тайлан мэдээлэлд хяналт шалгалт, дотоод аудит, хяналт хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж байгаа бөгөөд хийсэн хяналт, аудит, үнэлгээний дүн, тайланг албан хаагчид, олон нийтэд дотоод сүлжээний цахим хуудас болон байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээлж байна.<br>ТӨБЗГ-ын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудитын дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын цахим хуудас, шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан мэдээлж байна. Үндэсний аудитын газраас ТӨБЗГ-ын 2022 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 06 сарын 22 өдөр А-1/1244 тоот албан бичгээр хүргүүлсэн. Шилэн дансны **https://info.shilendans.gov.mn** цахим системд байршуулан мэдээлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 5 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | **ТӨБЗГ – ХЭЗХ, МТА**<br>Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан байршуулах боломжийг бүрдүүлсэн. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй. Харин https://d.parliament.mn цахим системийг өөрийн байгууллагын цахим систем https://pcsp.gov.mn -тэй холбож, УИХ-д өргөн мэдүүлсэн байгаа салбарын хууль тогтоомж, тооцоо судалгаа, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй танилцах боломжийг хялбаршуулсан. Тухайлбал, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өмчит компанийн тухай хуулийн төсөл, Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн тухай тогтоолын төсөл зэрэгтэй хялбар танилцах боломжийг бий болгов. | | |
| | 6 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болох “Алсын хараа 2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан цаглаврын дагуу тайланг гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Тайланг байгууллагын цахим хуудасны холбогдох цэст байршуулж, нээлттэй байдлыг хангаж хэвшсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 7 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | **ТӨБЗГ – ХЭЗХ, ЗУХ**<br>Байгууллагын цахим хуудасны https://pcsp.gov.mn/?page_id=4759 цэс болон тухай төрөлжсөн цэсүүдэд үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бусад эрх зүйн актуудыг байршуулж, олон нийтийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байна.<br>Байгууллагын цахим хуудсанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Иргэний хууль, Орон сууц хувьчлах тухай хууль, Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам, Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын тогтоолоор болон ТӨБЗГ-ын шийдвэрээр батлагдсан төрийн өмчийн харилцааны асуудалтай холбоотой холбогдох хууль тогтоомж, журам, аргачлал зэргийг байршуулсан.<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар ТӨБЗГ-ын ээлжит хуралдааныг нийт 17 удаа зохион байгуулж, хууль тогтоомжоор хүлээсэн эрх хэмжээний хүрээнд төрийн өмчийн харилцааны асуудлаар холбогдох шийдвэрийг гарган хэрэгжилтийг хангуулж байна. Тайлант хугацаанд хуралдаанаас гарсан шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор ТӨБЗГ-ын http://pcsp.gov.mn/ цахим хуудасны Ил тод байдал-Газрын тогтоол хэсэгт 2023 онд гарсан 340 тогтоол, 16 тэмдэглэл, нийт 356 шийдвэрийг тухай бүр байршуулсан болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 8 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Байгууллагын хаяг, байршил, албан хаагчдын харилцах утасны дугаар, шуудангийн хаягууд, албан тушаалын тодорхойлолтыг ТӨБЗГ-ын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn -д холбогдох буланг нээж байршуулсан. Цахим хуудасны холбогдох холбоос:<br>https://pcsp.gov.mn/?page_id=4558,<br>https://pcsp.gov.mn/?page_id=4953#,<br>https://pcsp.gov.mn/?page_id=5569. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 9 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг байгууллагын цахим хуудас https://pcsp.gov.mn -д тусгайлан булан нээж байршуулан мэдээлж байна.<br>Холбоос: https://pcsp.gov.mn/?page_id=4782.<br>Тайлант хугацаанд, ТӨБЗГ-т хүлээж авсан нийт 119 өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 80.7 хувьтай, 23 өргөдөл, гомдлыг шийдвэрлэхээр судалж байна. ТӨБЗГ-ын 2023 оны дотоод хяналт шалгалт, аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хариутай бичгийн шийдвэрлэлтэд тус тус дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 10 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | **ТӨБЗГ – ТӨБАХ, МТА**<br>Энэ хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, тайлант хугацаанд байгууллагын албан ёсны цахим хуудсыг хөгжүүлэх, хуульд нийцүүлэх, мэдээллийн шинэчлэл хийхэд анхаарав. Хуулийн энэхүү заалтад дурдсан мэдээллийг нээлттэй байршуулах боломжийг цахим системд бий болгон статистик мэдээллийг байршуулан мэдээлж байна. Энэ хүрээнд цахим хуудсанд уг мэдээллийг байршуулан мэдээлэх боломжийг бүрдүүлсэн. 2022 онд зохион байгуулсан төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод хөгжүүлэн ашигласан эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн системийг тодорхой түвшинд өргөжүүлж, зарим мэдээллийг нэмэх, боловсруулах, тухайлбал, хөрөнгийн орлого, зарлага, шилжилт хөдөлгөөн, их засвар, капиталжуулалт, данснаас хасах зэрэг үйлдлийг нэмж оруулан ашиглаж, төрийн болон орон нутгийн өмчит нийт 7113 хуулийн | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | этгээдийн захиргааны статистикийн мэдээ тайланг 2022 оны байдлаар цахимаар авч нэгтгэн 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний Статистикийн хороонд medee@nso.mn цахим хаягаар хүргүүлсэн. | | |
| | 11 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**<br>Энэ хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, тайлант хугацаанд байгууллагын албан ёсны цахим хуудсыг хөгжүүлэх, хуульд нийцүүлэх, мэдээллийн шинэчлэл хийхэд анхаарав.<br>Сургалт, семинар зохион байгуулагдахтай холбоотой тухайн арга хэмжээний хөтөлбөр, мэдээллийг байгууллагын цахим хуудас, фэйсбүүк пэйж хуудсанд байршуулан мэдээлсэн байна.<br>Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу дараах мэдээллийг нээлттэй ил тод болгон https://shilen.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Үүнд: Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан түрээслэгчдийн жагсаалт (2017-2023 он хүртэл). | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 12 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын дагуу Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтний 1 сул орон тооны нээлттэй захиалгыг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А-1/2380 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Сул орон тооны захиалгын зар Төрийн албаны зөвлөлийн болон ТӨБЗГ-ын албаны цахим хуудсанд нээлттэй мэдээлэгдсэн. Тухайн зарлагдсан сул орон тооны сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлөөс 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Уг сонгон шалгаруулалтад 7 нэр дэвшигч хамгийн өндөр оноогоор шалгарсан нэр дэвшигчийг Төрийн албаны зөвлөлөөр нэр дэвшүүлж, холбогдох шийдвэр, дүгнэлт, материалыг тус байгууллагад ирүүлсэн. ТӨБЗГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Б/18 дугаар тушаалаар тухайн нэр дэвшигчийг томилж, сул орон тоон хууль тогтоомжийн дагуу нөхсөн болно. Байгууллагын батлагдсан 54 орон тоонд 2023 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 52 төрийн албан хаагч, үүнээс төрийн захиргааны 43, төрийн үйлчилгээний 9 албан хаагч ажил үүрэг гүйцэтгэж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 13 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн албаны хууль тогтоомжоор батлагдсан сонгон шалгаруулалтын журам, холбогдох хууль тогтоомжийг байгууллагын цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” хэсэгт байршуулсан. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 14 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | **ТӨБЗГ – ЗУХ, Ёс зүйн зөвлөл, МТА**<br>Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын цахим хуудас болон байгууллагын дотоод сүлжээний цахим систем, мэдээллийн самбарт тус тус байршуулж, олон нийт болон албан хаагчдад нээлттэй мэдээлсэн байна.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах тухай” А/24 дүгээр тушаалаар байгууллагын Ёс зүйн зөвлөлийг Захиргаа, удирдлагын хэлтсийн даргаар ахлуулан, 5 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулаад байна.<br>Төрийн албаны тухай хууль болон шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ыг ТӨБЗГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/35 дугаар тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд уг журмаар төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг ажилтны эрх үүрэг, ажлын хариуцлага, дотоод хяналт, дэг журмын хүрээнд нарийвчлан зохицуулж өгсөн.<br>Монгол Улсын Их Хурлаас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр баталсантай холбогдуулан байгууллагын дотоод сүлжээ https://www.able.mn/main.php?p=cHiVbGlj -ний цахим системээр албан хаагчдад уг хуулийг сурталчлан танилцуулах арга хэмжээ авсан байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 15 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 16 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 | **ТӨБЗГ – ЗУХ, МТА** | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Хүний нөөцийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээлж байна. | | |
| | 17 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ыг байгууллагын дотоод сүлжээ болон албан ёсны цахим хуудсанд байршуулж, нийт албан хаагчид болон олон нийтэд нээлттэй мэдээлсэн байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 18 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Тухайн мэдээллийг Шилэн дансны цахим систем болон мэдээллийн самбарт байршуулан нийтэд мэдээлсэн.<br>ТӨБЗГ-ын 2022 оны төсвийн төслийн саналд тусгагдсан зардлыг 246,901,800 төгрөгөөр бууруулж, 3,360,717,300 төгрөгөөр баталсан байна. Төсөвт 2022 оны 2 дугаар сард тодотгол хийн 165,287,000 төгрөгөөр бууруулж 3,195,430,300 төгрөгөөр баталсан. Мөн 2022 оны 04 сарын 29-ны өдрийн тодотголоор 1,222,493,600 төгрөгөөр бууруулан 1,972,936,700 төгрөгөөр баталсан. Энэ бууралтын гол шалтгаан нь төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн программ хангамж, тоног төхөөрөмжийн зардлыг шууд хассантай холбоотой байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 19 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Тухайн мэдээллийг Шилэн дансны цахим систем болон мэдээллийн самбарт байршуулан нийтэд мэдээлсэн.<br>Тайлант оны батлагдсан төсвийг 1,222,493,600 төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,967,936,700 төгрөгийг улсын төсвөөс, 5,000,000 төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.<br>Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,967,749,500 төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 5,000,000 төгрөг нийт 1,972,749,500 төгрөгийн орлого бүрдүүлэн, урсгал үйл ажиллагааны зардалд 1,720,158,230.50 төгрөгийг зарцуулж, 247,591,269,490 төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 20 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай** 2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Үндэсний аудитын газраас хийсэн 2022 оны санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлттэй дүгнэгдсэн. Аудитын дүгнэлтийг Шилэн дансны https://info.shilendans.gov.mn цахим систем болон мэдээллийн самбарт нээлттэй мэдээлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 21 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай** 2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,720,158,230.51 төгрөг буюу 87.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 247,068,069.49 төгрөгөөр, Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын зардлыг 523,200 төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Уг мэдээллийг шилэн дансны https://info.shilendans.gov.mn цахим систем болон мэдээллийн самбарт нээлттэй мэдээлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 22 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай** 2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА** ТӨБЗГ-ын 2023 оны эхний хагас жилийн байдлаар байр ашиглалтын санхүүжилтээр Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгэний газартай гэрээ байгуулан ажилласны дагуу байр ашиглалтын зардалд 134,206,800 төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн. Шилэн дансны https://info.shilendans.gov.mn цахим системд холбогдох мэдээллийг байршуулан мэдээлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 23 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай** 2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий 134,206,800 төгрөгийн зардлыг зарцуулсан. Уг зардлаар Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгэний газартай байгуулсан гэрээний дагуу байр ашиглалтын зардлыг санхүүжүүлсэн. Гүйлгээний мэдээллийг агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансны https://info.shilendans.gov.mn цахим системд байршуулж, нээлттэй мэдээлэв. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 24 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай** 2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, | **ТӨБЗГ – ЗУХ, МТА** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр байхгүй. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | | | |
| | 25 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Шилэн дансны тухай хууль, журмын дагуу төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг холбогдох цахим систем https://shilendans.gov.mn/organization/8324 болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны https://shilendans.gov.mn/organization/8324 цахим системд төсөв, санхүү, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 13 төрлийн 33 мэдээ оруулахаас 30 мэдээг графикт хугацааны дагуу мэдээлсэн 3 мэдээ хугацаа болоогүй хүлээгдэж байна, 1 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн төлөвтэй байна. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 4 төрлийн 13 мэдээг, бусад 7 төрлийн 37 мэдээг мэдээлэхээс бүрэн байршуулан нээлттэй мэдээлсэн байна. Нийт дүнгээр шилэн дансанд нийт 24 төрлийн 83 мэдээллийг мэдээлэхээс 80 мэдээг мэдээлсэн, 3 мэдээг мэдээлэх хугацаа болоогүй хүлээгдэж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 26 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулсан. Төлөвлөгөөг шилэн дансны https://shilendans.gov.mn/organization/8324 цахим систем, байгууллагын цахим хуудасны холбогдох хэсэг болон мэдээллийн самбарт байршуулан нээлттэй мэдээлсэн.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу зарлах тендер шалгаруулалтын ажил байхгүй бөгөөд холбогдох төсөв, санхүүжилт төсөвт тусгагдаагүй болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 27 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01 | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ, аудит, бусад шалгалт байхгүй болно. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | | | |
| | 28 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаатай холбоотой тендер шалгаруулалт хийгдээгүй тул оролцогчдод өгөх зөвлөгөө, зааварчилга хийгдээгүй. Харин байгууллагын нярав, нягтлан өөрчлөгдөн томилогдсонтой холбоотой зөвлөгөө, зааварчилга өгөх, холбогдох сургалтад хамруулах ажил хийгдсэн байна. Тухайлбал, Ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшүүлэх сургалтад, нярав нь нярвын мэргэшсэн нярвын сургалтуудад тус тус хамрагдсан бөгөөд уг сургалтуудаар энэ чиглэлийн арга зүй, мэдээллээр мөн хангагдсан болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 29 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй тул энэ талаар шилэн дансны цахим системийн холбогдох хэсэгт мэдэгдсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 30 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**<br>ТӨБЗГ-ын захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” | |
| | 31 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Шилэн дансны тухай хууль, журмын дагуу төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг холбогдох цахим систем https://shilendans.gov.mn/organization/8324 болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны https://shilendans.gov.mn/organization/8324 цахим системд төсөв, санхүү, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 13 төрлийн 33 мэдээ оруулахаас 30 мэдээг графикт хугацааны дагуу мэдээлсэн 3 мэдээ хугацаа болоогүй хүлээгдэж байна, 1 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн төлөвтэй байна. Хөрөнгө оруулалт, худалдан авах | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагаатай холбоотой нийт 4 төрлийн 13 мэдээг, бусад 7 төрлийн 37 мэдээг мэдээлэхээс бүрэн байршуулан нээлттэй мэдээлсэн байна. Нийт дүнгээр шилэн дансанд нийт 24 төрлийн 83 мэдээллийг мэдээлэхээс 80 мэдээг мэдээлсэн, 3 мэдээг мэдээлэх хугацаа болоогүй хүлээгдэж байна. | | |
| | 32 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | **ТӨБЗГ – ХЭЗХ, МТА**<br>Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд байгууллагын цахим хуудас болон байгууллагын фэйсбүүк пэйж хуудсанд өөрийн үйл ажиллагаатай холбогдох хуулийн шинэчлэлийн төслүүд, холбогдох мэдээлэл судалгааг олон нийтэд танилцуулж, санал авч ажилласан. Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас хөтөлж байгаа https://d.parliament.mn цахим системийг өөрийн байгууллагын цахим систем https://pcsp.gov.mn -тэй холбож, УИХ-д өргөн мэдүүлсэн байгаа салбарын хууль тогтоомж, тооцоо судалгаа, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй танилцах боломжийг хялбаршуулсан. Тухайлбал, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай анхдагч хуулийн төсөл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төсөл, тэдгээртэй холбоотой танилцуулга, мэдээлэл, судалгаа, материалыг өөрийн болон холбогдох цахим хуудас, хэлэлцүүлэг, хурлуудаар дамжуулан мэдээлж, олон нийтийн санал авах ажлыг зохион байгуулсан. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 33 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын байршилтай холбоотой хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн шийдвэрт өөрчлөлт ороогүй. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 34 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Нийслэлийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 07 өдрийн А/1176 тоот шийдвэртэй, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 хороо, Жигжиджавын гудамж хаягт байрлах 1500400111 нэгж талбарын дугаар бүхий 1079.0 м.кв газрыг Төрийн захиргааны байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшихээр эрхийн бүртгэлийн Э-2202000069 дугаарт бүртгүүлж гэрчилгээ эзэмшиж байна. Уг мэдээлэл нь И-Монгол цахим | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | системд бүртгэлтэй. Байршил, хаяг, эзэмшиж байгаа газрын мэдээллийг нээлттэй мэдээлсэн байна. | | |
| | 35 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | **ТӨБЗГ – ТӨУЗХ, МТА**<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авсан.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцсэн, төрийн болон орон нутгийн өмчийн асуудлаарх өмчийн харилцааны чиглэлээр гарсан тогтоол, тэмдэглэлүүдийг байгууллагын албан ёсны цахим хуудасны холбогдох цэсэд байршуулан нээлттэй мэдээлж хэвшсэн. Цахим хуудас дахь холбогдох холбоос: https://pcsp.gov.mn/?page_id=4751#.<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашгийн талаарх мэдээллийг нэгтгэсэн товхимлыг жил болгон шинэчлэн гаргаж, сурталчлан танилцуулж байгаа. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 36 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | **ТӨБЗГ – ТӨУЗХ, МТА**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцсэн, төрийн болон орон нутгийн өмчийн асуудлаарх өмчийн харилцааны чиглэлээр гарсан тогтоол, тэмдэглэлүүдийг байгууллагын албан ёсны цахим хуудасны холбогдох цэсэд байршуулан нээлттэй мэдээлж хэвшсэн. Эдгээрийн дотор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, бүтэц, зохион байгуулалтыг батлах гэх мэт төрийн өмчийн удирдлага, менежментийн асуудлаар гарсан тогтоол, тэмдэглэл тусгагдсан болно. Цахим хуудас дахь холбогдох холбоос: https://pcsp.gov.mn/?page_id=4751#.<br>Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх болон Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлаж, “Авлигатай тэмцэх 5 үйл ажиллагаа” хэрэгжүүлэхээр тогтсонтой холбоотой “Шил ажиллагаа”-ны хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг компани, үйлдвэрийн газрын захирлуудын мэдээлэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цахим хаяг, 1 сарын цалингийн мэдээллийг нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хуулийн дагуу https://shilen.gov.mn цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах тухай мэдээллийг өдөр тутмын сонин хэвлэл, цахим хуудсанд нийтэлж, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын мэдээллийг нэгдсэн товхимолд тусган хэвлэж, түгээсэн. Мэдээллийн сан үүсгэсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна. “Цемент шохой” ТӨХК, “Дорноговь АЗЗА” ТӨХК, “Багануур АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК, “Говь-Алтай АЗЗА” ТӨХК, “Увс АЗЗА” ТӨХК, “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын гүйцэтгэх захирал, захирлуудыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилоод байна. | | |
| | 37 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br><br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br><br>8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | **ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ, ЗУХ, МТА**<br><br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэлтэй холбоотой газрын тогтоол шийдвэрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны цахим хуудас https://pcsp.gov.mn -ийн тогтоол шийдвэрийн буланд тогтмол нийтэлж, хэрэгжилт, үр дүнг интернетийн сүлжээнд программ хангамж, өгөгдлийн боловсруулалтын daadar system -ээр нэгтгэн мэдээлж байна.<br><br>Төрийн өмчийн илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлсний орлогоос 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавих ажлын хүрээнд улсын төсөвт тайлант хугацаанд буюу 1-6 дугаар сард нийт өссөн дүнгээр нийт 848,872,534.52 төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээд байна. Эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдаанаас 1-6 дугаар сард өссөн дүнгээр нийт 486,819,377.75 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, хөрөнгийн дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулсан. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 38 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨБАХ, МТА**<br>Ашиглалтад оруулахаар барьж байгаа барилга, байгууламж байхгүй. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” | |
| | 39 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зардлаар суралцаж байгаа албан хаагч байхгүй. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 40 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021-12-17, Хэрэгжиж эхлэх: 2022.05.01<br>8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6. Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасныаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авсан.<br>Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгох чиглэлээр байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан хууль тогтоомжид заасан мэдээллийг нээлттэй мэдээлж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| 3 | 41 | **Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль**<br>2021-12-24, Хэрэгжиж эхлэх: 2022-02-07 (Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 оны, №05 )<br>11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨХШХ, ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Улсын Их Хурлын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх асуудлаар Засгийн газарт өгсөн үүргийг хэрэгжүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт Засгийн газраас өгсөн үүрэг одоогоор байхгүй байна.<br>Харин, Засгийн газраас Монгол Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Байнгын хорооны холбогдох тогтоолын хэрэгжилтийг хагас жил тутамд гаргуулж, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. Тухайлбал, ТӨБЗГ-аас 2022 оны жилийн эцсийн байдлаар УИХ-ын 7 тогтоолын холбогдох 15 заалтын хэрэгжилтийг, УИХ-ын Байнгын | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.) | хорооны 3 тогтоолын холбогдох 3 заалтыг тус тус Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар УИХ-ын 11 шийдвэрийн 26 заалтын, УИХ-ын Байнгын хорооны 5 тогтоолын 9 заалтын, нийт 15 тогтоолын 35 заалтын хэрэгжилтийг энэхүү тайланд тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байгаа болно. | | |
| | 42 | **Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль**<br>2021-12-24, Хэрэгжиж эхлэх: 2021-12-24<br>15.3. Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын хэрэгжилтийг тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй. | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨХШХ, ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Засгийн газраас Монгол Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Байнгын хорооны холбогдох тогтоолын хэрэгжилтийг хагас жил тутамд гаргуулж, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. Тухайлбал, ТӨБЗГ-аас 2022 оны жилийн эцсийн байдлаар УИХ-ын 7 тогтоолын холбогдох 15 заалтын хэрэгжилтийг, УИХ-ын Байнгын хорооны 3 тогтоолын холбогдох 3 заалтыг тус тус Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар УИХ-ын 11 шийдвэрийн 26 заалтын, УИХ-ын Байнгын хорооны 5 тогтоолын 9 заалтын, нийт 15 тогтоолын 35 заалтын хэрэгжилтийг энэхүү тайланд тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байгаа болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | | **МУ-ын хууль: 3 хуулийн 42 заалт:** | **100% - 38 заалт; ХБ – 4 заалт.** | **Дундаж үнэлгээ: 100%** | |
| | | | **Хоёр. УИХ-ын тогтоол** | | |
| 4 | 43 | **Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>2020-01-09, № 02<br>ТӨБЗГ хуулийн төсөл 2020. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн ЗГ-1/146 дугаартай албан бичгээр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцээд Үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. Уг хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхэд анхаарч холбогдох зохицуулалтыг тусгасан болно. Хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр МУИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна. Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тогтоолоор уг ажлын хэсэгт чиглэл өгсний дагуу тодорхой ажлуудыг нэмж хийхээр зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна. | | |
| 5 | 44 | **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br><br>2020-12-04, № 39<br><br>1.5/. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төслийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын санхүүжилтээр 2020 оноос эхлүүлж, 4 үе шаттайгаар хэрэгжилтийг зохион байгуулж байна.<br><br>Төслийн I болон II ээлжийн ажлыг 2021 оны 8 дугаар сараас эхлүүлж, худалдан авах ажиллагааг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зарласан. Энэ шатанд төлөвлөгдсөн 16 аймгийн 92 сумын 307 объектоос байнгын ашиглалтад хүлээн авсан 190 объект, Комисс ажиллуулах бэлтгэл хангаж буй 22 объект, ажил үргэлжилж буй 95 объект байна. I, II ээлжийн барилга угсралтын явц 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Ашиглалтад орсон объектуудын ашиглалтын явцад хяналт хийж, гэмтэл, засварыг цаг алдалгүй хийхэд анхаарч ажилласан байна.<br><br>Төслийн III болон IV ээлжийн тухайд эхлээд зөвлөх үйлчилгээг зохион байгуулж, ажлын зураг, төсвийг гүйцэтгүүлэн магадлалаар эцэслэснээр угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байна.<br><br>III ээлжид **17 аймгийн 330 сумын 303 объектыг хамруулж, зураг, төсвийг** шалгарсан 7 компани гүйцэтгэж байна. Зургийн ажил **80 хувийн гүйцэтгэлтэй** байна. Үүнээс ажлын зураг төсөл боловсруулж дуусан, магадлалаар хянагдаж, угсралтын ажлын тендерийг зарлах ажлууд хийгдэж байна. Тухайлбал, Архангай, Хэнтий, Баян-Өлгий, Ховд, Дундговь, Сэлэнгэ, Булган, Увс гэсэн 8 аймгийн 64 сумын нийт 213 объектын зураг магадлалаар хянагдсан. Эдгээрээс Увс аймгийн 11 суманд дахь 34 объектын тендерээс бусад нь зарлагдсан. Увсын тендерийг зарлахаар ажлын даалгавар боловсруулж байна. Нийт 6 аймгийн 62 объектын зураг магадлалаар хянагдах шатанд байна. Үлдсэн 3 аймгийн 108 объектын ажлын зураг, төсөв хийгдэж байна.<br><br>IV ээлжид 18 аймгийн 92 сумын 243 объектыг хамруулан гүйцэтгэнэ. Зураг, төсвийн зөвлөх үйлчилгээг зарлаж, дэлгэрэнгүй болон хураангуй гэсэн 2 үе шаттайгаар тендерийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс, 14 аймгийн зураг төслийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, гүйцэтгэгч компаниуд судалгааны ажлыг эхлүүлээд эхний байдлаар Завхан аймгийн судалгаа дуусч, хөрсний судалгаа хийх, дотор ариун цэврийн өрөөний ажлын зураг хийж эхэлсэн. Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Төв гэсэн 4 аймгийг дахин зарлаж, 7 дугаар сарын 18-ны өдөр хураангуй жагсаалтын үр дүнг нээнэ.<br><br>**Санхүүжилтын тухайд:** Төслийн I болон II ээлжийн 307 объектын гүйцэтгэгчийг "Түлхүүр гардуулах нөхцөлт гэрээ"-гээр хэрэгжүүлсний | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | улмаас ажлын гүйцэтгэл болон технологийн шийдэлд хүндрэлүүд гарсан. 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 35.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгоод байна.<br><br>Тухайн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын хүчин чадлаас хамаарч нэг объектын ариун цэврийн байгууламжийг бүрэн шийдвэрлэх магадлалаар хянагдсан зураг, төсвийн бодит өртгийг дундажлахад 160.0-180.0 сая төгрөг болж байна. Тухайлбал, Архангай аймгийн Хайрхан сумын дотуур байрын ариун цэврийн байгууламжийн төсөв 276.1 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламжийн төсөв 147.8 сая төгрөг, Хэнтий аймгийн Батноров сумын хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн төсөв 104.9 сая төгрөгөөр хянагдсан.<br><br>Төслийг хэрэгжүүлэхээр 100.0 тэрбум төгрөгийн төсвийг төлөвлөж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол гарсан. Иймд төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төслийг 2024 оны эхний хагас жилд багтаан дуусгахад шаардагдах үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэсэн байна. | | |
| 6 | 45 | **Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай**<br><br>2021-01-22, №12<br><br>3. Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br><br>2023 оны эхний хагас жилд Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дор дурдсан асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр холбогдох мэдээлэл, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br><br>Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Уг асуудлыг УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай асуудлыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн байна. УИХ-ын зарим гишүүдийн зарчмын зөрүүтэй санал гарсантай холбоотой тогтоолын төслийг хууль тогтоомжийн санаачлагчид буцаасан тул УИХ-ын тогтоолын төслийг дахин өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 46 | **Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай**<br>2021-01-22, №12<br>4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br>Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан тус байгууллагын чиг үүрэгт шууд хамаарал бүхий Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулахад Засгийн газар болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас байгуулсан ажлын хэсгүүдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан ажиллуулж байгууллагын чиг үүрэгтэй холбоотой байр суурийг илэрхийлэх, холбогдох саналыг тусгуулах, ажлын хэсгийн шаардсан холбогдох судалгаа, тооцооллыг гаргаж хүргүүлэх чиглэлээр хамтран ажиллав. Дээрх 2 хуулийн төслийг хууль санаачлагчдаас УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд хэлэлцэх эсэх асуудлыг нэгдсэн чуулганаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороонд тус тус шилжүүлсэн. Уг Байнгын хорооны дэргэд УИХ-ын даргын захирамжаар УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна.<br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Засгийн газрын хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр болон ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийн дагуу тухай бүр тайлагнах хүрээнд уг үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 47 | **Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай**<br>2021-01-22, №12<br>ЗГХЭГ хуулийн төсөл 2021. Кибер аюулгүй байдлын тухай Гүйцэтгэх ажлын тухай /Шинэчилсэн найруулга/ Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Нийслэлийн эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Цахим гарын үсгийн | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан бөгөөд уг төслийг Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн барихыг дэмжсэний дагуу 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр УИХ-д өргөн барьсан. УИХ-ын 06 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэн Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ажлын хэсэг байгуулж, ахлагчаар нь УИХ-ын гишүүн Б.Энхбаярыг томилсон. Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг 43 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж байна. Ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл оролцож байгаа, | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Баялгийн сангийн тухай, **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай** | Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Б.Энхбаярын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу гишүүд тодорхой үүрэг, чиглэлээр ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн ажилтай уялдуулах чиглэлтэй ажиллаж байгаа.<br><br>МУИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд “Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, эдгээр хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулан ажиллуулж байна. Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор уг ажлын хэсэгт чиглэл өгсний дагуу тодорхой ажлуудыг нэмж хийхээр зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна. | | |
| | 48 | **Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай**<br><br>2021-01-22, №12<br><br>ТӨБЗГ. хуулийн төсөл 2021. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай /Шинэчилсэн найруулга/ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн ЗГ-1/146 дугаартай албан бичгээр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцээд Үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. Уг хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхэд анхаарч холбогдох зохицуулалтыг тусгасан болно. Хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр МУИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна. Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор уг ажлын хэсэгт чиглэл өгсний дагуу тодорхой ажлуудыг нэмж хийхээр зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | 49 | **Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2021-11-12, № 88<br>1.2/. Засгийн газраас дэвшүүлсэн төсвийн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн төрийн албанд ашиглаж байгаа суудлын автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, зэвсэгт хүчин, цагдаа, тагнуул, онцгой байдал, эрүүл мэндийн байгууллагаас бусад төрийн байгууллагын суудлын автомашины хэрэглээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр үе шаттайгаар хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах; | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 195/260 дугаар хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, тарийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталсан. Уг журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрийн өмчит нийт хуулийн этгээдэд мэдэгдэх, тухайн хуулийн этгээдийн автомашины тоо төрлийг тогтооход шаардлагатай мэдээллийг ирүүлэх талаар 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А-1/194 дүгээр албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Уг албан бичигт дурдсан шаардлагатай мэдээллийг төрийн өмчит хуулийн этгээдээс ирүүлснийг нэгтгэж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| 8 | 50 | **Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2021-11-25, № 94<br>1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дүрмийн сангийн Монголын талын хувь хэмжээг 83,673,494,098 /наян гурван тэрбум зургаан зуун далан гурван сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга ерэн найм/ төгрөгөөр, Оросын талын хувь хэмжээг ижил хэмжээгээр нэмэгдүүлэх асуудлаар Оросын талтай хэлэлцээ хийхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | **ТӨБЗГ –ТӨУЗХ**<br>Засгийн газраас Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 380 дугаар тогтоолоор “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дүрмийн сангийн Монголын талын хувь хэмжээг 83,673,494,098 /наян гурван тэрбум зургаан зуун далан гурван сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга ерэн найм/ төгрөгөөр нэмэгдүүлсэн. 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-д айлчлах үеэрээ Монголын талын саналыг тус улсын эрх баригчдад мэдэгдэж, тэдний зүгээс зөвшөөрсөн хариуг авсан байна.<br>Энэ хүрээнд ОХУ-ын талаас “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхэд шаардлагатай 83.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хөрөнгийг төмөр замын машин угсрах эд материал хэлбэрээр гаргах тухай саналыг тусгасан харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг 2022 оны 03 дугаар сард Монгол Улсын Сангийн яаманд ирүүлж, 6 дугаар сард 2 улсын Сангийн сайд санамж бичигт гарын үсэг зурсан байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 51 | **Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2021-11-25, № 94<br>2. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн | **ТӨБЗГ –ТӨУЗХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 380 дугаар тогтоолоор “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхэд Монголын талаас шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг “МОН-П1”, “МОН-П2” хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрийн авлагаас | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дүрмийн санг нэмэгдүүлэхэд Монголын талаас шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Японы Олон улсын хамтын ажиллагааны банкнаас тус нийгэмлэгт төмөр замын тээврийг сэргээн сайжруулахад зориулан олгосон "МОН-П1", "МОН-П2" хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрийн авлагаас шилжүүлэн тооцох замаар бүрдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй. | шилжүүлэн тооцох замаар бүрдүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсөн. | | |
| | 52 | **Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2021-11-25, № 94<br><br>3. Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг Оросын талтай тохиролцсон тохиолдолд тус нийгэмлэгт олгосон "МОН-П1", "МОН-П2" хөнгөлөлттэй зээлийн үлдэгдлийг Монголбанкны 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлж, уг өдрөөс хойш тооцогдсон хүү, алдангийн төлбөрийг чөлөөлж, дүрмийн санг нэмэгдүүлэхээс бусад зээлийн үлдэгдэл төлбөрийг Японы Олон улсын хамтын ажиллагааны банканд төлөх хуваарьтай уялдуулан 2021-2025 онд багтаан төлүүлэх арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | **ТӨБЗГ –ТӨУЗХ**<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 380 дугаар тогтоолоор Оросын талтай хэлэлцээ хийж дуусах хүртэлх хугацаанд "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхээс бусад зээлийн үлдэгдэл төлбөрийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дамжуулан зээлдүүлэх гэрээний хуваарьт 2021 оноос эхлэн төлөхөөр заасан хэмжээгээр Улсын төсөвт төлж, хэлэлцээр байгуулсан тохиолдолд 2025 он хүртэл төлөх нөхцөлөөр дамжуулан зээлдүүлэх гэрээг шинэчлэн байгуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасан.<br><br>Сангийн яаманд 2021, 2022 оны зээлийн графикт төлбөрт 20.21 тэрбум төгрөг төлсөн. Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг Монгол Улсын Шадар сайд 2023 оны 6 дугаар сард ОХУ-д хийсэн айлчлалын хүрээнд Оросын талтай харилцан тохиролцсон учир тус нийгэмлэгт олгосон "МОН-П1", "МОН-П2" хөнгөлөлттэй зээлийн үлдэгдлийг Монголбанкны 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлж, уг өдрөөс хойш тооцогдсон хүү, алдангийн төлбөрийг чөлөөлж, дүрмийн санг нэмэгдүүлэхээс бусад зээлийн үлдэгдэл төлбөрийг Японы Олон улсын хамтын ажиллагааны банканд төлөх хуваарьтай уялдуулан 2021-2025 онд багтаан төлүүлэх төгрөгийн төлбөрийн график батлагдаж, гэрээнд гарын үсэг зурсан байна. | "Бүрэн хэрэгжсэн" - 100% | |
| 9 | 53 | **Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай**<br><br>2022-04-29, № 16<br><br>1.2. Үндсэн чиглэлд заасан хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, биржээр олон | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор "2022-2023 онд биржээр төрийн мэдлийн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн | "Бүрэн хэрэгжсэн" - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийтэд нээлттэй худалдаж, нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд даалгасугай. | этгээдийн жагсаалт”-ыг баталж, УИХ-ын тогтоолоор батлагдсан үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан.<br>Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолын дагуу ТӨБЗГ нь 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна.<br>“Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй компани болгох ажлын хүрээнд авто замын засвар, арчлалтын чиглэлээр ажилладаг төрийн өмчит 20 компанийг нэгтгэн “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, түүний энгийн хувьцаа нэмж гаргах, биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн 05 дугаар тэмдэглэл гаргасан бөгөөд холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр тогтсон.<br>“Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд нээлттэй худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-1/448 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 220 дугаар тогтоол гаргасан байна. | | |
| 10 | 54 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2022-11-11, № 72<br>1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ**<br>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдан батлагдаагүй болно. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах; | | | |
| | 55 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2022-11-11, № 72<br>1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ**<br>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан нийт 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудал Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан байсан боловч Төрийн хэмнэлтийн хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой уг арга хэмжээний санхүүжилт цуцлагдсан. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудал Монгол Улсын 2023 оны 2023 оны төсвийн тухай хуулиар шийдвэрлэгдээгүй болно.<br>2023 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ байхгүй болно. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 56 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2022-11-11, № 72<br>1.7. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох, ашигт малтмал олборлох, боловсруулах, тээвэрлэх зэрэг бүх үе шатанд хамаарах гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлж, экспортод гаргах, нууцын зэрэглэлд хамаарах худалдах, худалдан авах гэрээг Улсын Их Хуралд танилцуулах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, авлигатай тэмцэх 5 үйл ажиллагаа буюу “Шүгэл ажиллагаа”, “Шүүр ажиллагаа”, “Шувуу ажиллагаа”, “Шилжүүлэн авах ажиллагаа”, “Шил ажиллагаа"-г тус тус хэрэгжүүлэхээр тогтсонтой холбоотойгоор Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангийн хийсэн уулзалтад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдах бүрэлдэхүүн, зарим албан хаагчид, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захирлуудыг бүрэн оролцуулах арга хэмжээг зохион байгуулав.<br>Уг уулзалтын үеэр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд "Шүүр" ажиллагааны хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих систем”, “Шүүр ажиллагаа”-ны талаарх танилцуулга, мэдээлэл хийгдэж, бусад | “Хэрэгжээ-гүй” – 0% | Урт хугацааны туршид, санхүүжил-тийн асуудал шийдвэр-лэгдсэний үндсэн дээр цахим систем бий болно. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох мэдээллүүдийн талаар санал солилцож, нэгдсэн удирдлага, ойлголтоор хангагдлаа.<br><br>“Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих систем”-ийн хүрээнд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох асуудлыг дэмжих, цахим системүүдийн мэдээллийг нэгдсэн системтэй холбох зэрэг асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. | | |
| | 57 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-11-11, № 72<br><br>1.8. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх, хувийн хэвшлийн зонхилох байр суурийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц судалгаа хийж, бодлого боловсруулах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор “2022-2023 онд биржээр төрийн мэдлийн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ыг баталж, УИХ-ын тогтоолоор батлагдсан үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан.<br><br>Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолын дагуу ТӨБЗГ нь 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br><br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна.<br><br>“Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй компани болгох ажлын хүрээнд авто замын засвар, арчлалтын чиглэлээр ажилладаг төрийн өмчит 20 компанийг нэгтгэн “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, түүний энгийн хувьцаа нэмж гаргах, биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн 05 дугаар тэмдэглэл гаргасан бөгөөд холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр тогтсон.<br><br>“Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд нээлттэй худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-1/448 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 220 дугаар тогтоол гаргасан байна. | | |
| 11 | 58 | **Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>2023-01-19, № 08<br>3/в. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажилласан бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд уг тогтоолын заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| 12 | 59 | **Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай,**<br>2023-04-21, № 25<br>1.1. Хөдөө аж ахуйг дэмжих санг татан буулгасантай холбогдуулан тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өр төлбөр, авлагыг "Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүрэн шилжүүлэх; | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Ажлын хэсэг томилогдон ажилласны дараа шийдвэрлэнэ. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 60 | **Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай,**<br>2023-04-21, № 25<br>1.2. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хугацаа хэтэрсэн өр, авлагыг ангилж, улсын төсөвт төлөх өр төлбөрийг 2024 онд багтаан төлж барагдуулах үйл ажиллагаар хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Хүнс, хөдөө аж ахуйн яам ажилладаг тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уг заалт хамаарахгүй байна. | Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | ТӨБЗГ-т хамаарах-гүй байгаа тул цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 61 | **Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай,** | **ТӨБЗГ – ТӨУЗХ** | Хэрэгжил-тийг тооцох хугацаа | ТӨБЗГ-т хамаарах-гүй байгаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2023-04-21, № 25<br>1.4. "Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн засаглалыг төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх хүрээнд газар тариалан, мал аж ахуй эрхлэгчдийн болон мэргэжлийн холбоодын оролцоог хангасан олон нийтэд нээлттэй компани болгох арга хэмжээг үе шаттай зохион байгуулах; | "Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болох Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас энэ тогтоолын заалтад дурдсан тодорхой чиглэл, бодлого, саналыг гаргаж шийдвэрлэх ажлыг хариуцахаар байна. | болоогүй” – ХБ. | тул цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 62 | **Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай,**<br>2023-04-21, № 25<br>1.5. "Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн хуулийн этгээдтэй өрсөлдөхгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Хүнс, хөдөө аж ахуйн яам ажилладаг тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уг заалт хамаарахгүй байна. | Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | ТӨБЗГ-т хамаарах-гүй байгаа тул цаашид хяналтаас хасах саналтай. |
| 13 | 63 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2023-04-21, № 28<br>2.1. онцгой дэглэм тогтоосон 6 сарын хугацаанд багтаан компанийн удирдлага, зохион байгуулалтын оновчтой бүтцийг бий болгож, засаглалыг сайжруулж, гүйцэтгэх удирдлагыг ил тод, нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 23/04 дугаартай тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан. Шинэчилсэн дүрмээр “Эрдэнэс Монгол” нэгдлийг нэгдсэн удирдлагаар хангаж, компанийн зохион байгуулалтын бүтцэд стратеги төлөвлөлт, санхүүгийн нэгдсэн удирдлага, үйлдвэрлэл технологийн асуудал хариуцсан нэгжийг бий болгож, удирдлагыг толгой компанитай зөвшилцөн томилох заалт орсонтой холбоотойгоор компанийн бүтцийг холбогдох дүрэм, журамд нийцүүлэх арга хэмжээ аван ажиллаж байна. Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч компанийн засаглалын зарчмууд, компанийн бизнесийн стратегид нийцсэн оновчтой бүтцийг бий болгох зорилгоор одоогийн бүтэц, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийх, нэгжүүдийн чиг үүргийг бизнес төлөвлөгөөтэй уялдуулан шинэчлэх, ажлын байрны нэршлийг стандартад нийцүүлэх ажлуудыг үе шаттайгаар хийж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ажлын байр, албан тушаалын нэршлийг Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтод нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлууд хийгдэж байгаа бөгөөд судалгаа, чиг үүргийн шинжилгээнд | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тулгуурласан засаглалын оновчтой, үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлууд хийгдэж байна. | | |
| | 64 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2023-04-21, № 28<br>2.2. компанийн үйл ажиллагаанд олон улсын нэр хүндтэй, хөндлөнгийн аудитын компаниар нэн даруй аудит хийлгэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 457 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уул уурхайн бүх шатны үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл, тайлагнал, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын компаниар аудит хийлгэж дүгнэлт, зөвлөмж гаргуулан ажиллахыг үүрэг болгосны дагуу 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр худалдан авах ажиллагааг эхлүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5-д заасны дагуу тендер шалгаруулалтыг 3 удаа зарласан боловч уг тендер шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй тул амжилтгүй болсон. Тендер шалгаруулалт амжилтгүй болсон нөхцөл шалтгааныг тухай бүрд судлан үзэж шаардлагатай өөрчлөлтийг оруулан, мөн хуулийн 34.2-т заасны дагуу олон улсад нэр хүнд бүхий аудитын 4 компанид хэлэлцээ хийх урилга хүргүүлэн уулзалт зохион байгуулахад аудитын 2 компани буюу KPMG аудит, PWC аудит ХХК оролцох боломжгүй тухайгаа илэрхийлсэн. GRAND TORNTON аудит, EYA аудит ХХК гэсэн 2 аудитын компани оролцох боломжтой эсэхээ дахин судалж үзээд боломжтой тохиолдолд хариу мэдэгдэх тухайгаа илэрхийлсэн ба хэлэлцээ амжилтгүй болсон.<br>Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 07 дугаартай тогтоолоор төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан ба тендер шалгаруулалтыг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зарлан 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр нээлт хийхэд мөн нэг ч тендер ирүүлээгүй. 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр дахин зарлаж, 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдөр нээхэд 2 оролцогч тендер ирүүлсэн. Багц 1. “Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар 2021, 2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх” үйлчилгээнд ирүүлсэн “Мүүрь аудит” ХХК-ийн тендерийг Үнэлгээний хороо хянан үзэж, үнэлэн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт “...Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ. “ гэж заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн гэж үзэн гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн. “Мүүрь аудит” ХХК-тай гэрээ байгуулагдаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 65 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2023-04-21, № 28<br>2.3. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд эрх зүйн нийтлэг хэм хэмжээ, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг чанд сахин мөрдүүлж, олон улсын болон Монгол Улсын стандарт, шаардлагыг хангуулах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Тогтоолын заалтын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 66 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2023-04-21, № 28<br>2.4. онцгой дэглэм тогтоосон хугацаанд холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, цаашид хэвийн, тогтвортой ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчийн хурлаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, нэр дэвшигчдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилсон. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 67 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2023-04-21, № 28<br>2.5. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 08 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах талаар шуурхай арга хэмжээ авч, тус тогтоолын биелэлтийн явцыг сар бүр Улсын Их Хуралд танилцуулах. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж, танилцуулах ажлын хэсэг байгуулсан ба уг ажлын хэсэгт Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв, Гадаадын иргэн, харьяатын газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөөллийг (зөвшилцсөнөөр) оруулсан. "Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны бүртгэлийн талаарх болон нас барсан, Монгол улсын харьяатаас гарсан, шинээр төрсөн иргэний тоон мэдээ, мэдээллийг гаргах, шинээр төрсөн иргэнд хувьцааг эзэмшүүлэх, хувьцааны тоо ширхэг, эзэмшлийн хувьцаанаас хэрхэн шилжүүлэх талаар санал, танилцуулга бэлтгэх, хууль, эрх зүйн санал дүгнэлт гаргахтай холбоотойгоор ажлын төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.<br>2021 болон 2022 онуудын “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар тухайн ондоо хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахгүй байх шийдвэрүүд гаргаж байсан. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 сарын 28-нд болсон ба хурлаар онцгой байдлын дэглэм дуусах хүртэл Ноогдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн.<br>Засгийн газрын 2022.12.09-ний өдрийн 449-р тогтоолын хэрэгжилтийн хүрээнд нууцын зэрэгт байсан нүүрс тээвэрлэлт, экспорттой холбоотой | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 9 гэрээг ил болгож компанийн цахим хуудсанд байршуулсан. Мөн Ett.mn цахим хуудасны “Нээлттэй уурхай” буланд компанийн туслан гүйцэтгэх гэрээ, олборлолтын гэрээ, нүүрс борлуулалтын гэрээ, тээвэрлэлтийн нэгдсэн мэдээлэл, С зөвшөөрлийн мэдээлэл зэргийг ил тод байршуулан ажиллаж байна.<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 94 дүгээр тушаалаар "Тавантолгой-Зүүнбаян", "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төсөл, "Богдхан" төмөр замын төслийн хэрэгжилтэд болон "Зүүнбаян төмөр зам" ХХК, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий хамтарсан ажлыг хэсэг байгуулагдаж, ТӨБЗГ-аас 2022 оны 01/ТТЗ-ЗБТ дугаартай шалгалтын удирдамжийг баталсан. "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт болон "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн, мөн "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төсөл, "Богдхан" төмөр замын төслийн хэрэгжилтэд болон "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх дэд ажлын хэсгүүд байгуулагдан батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, дүн, тайланг танилцуулсан байна.<br><br>"Тавантолгой төмөр зам" ХХК-аас Олон улсын улс дамнан үйл ажиллагаа явуулдаг аудитын байгууллагаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулагдсан хөрөнгөд хөндлөнгийн аудитын үйлчилгээг хийлгэхээр 2023 оны 3 дугаар сарын 02-ны өдөр сонгон шалгаруулалтыг зарласан боловч амжилтгүй болж, 2023 оны 6 сарын 21-ний өдөр дахин зарлаад байна. | | |
| 14 | 68 | **Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br><br>2023-05-04, № 34<br><br>2. Хүрээлэнг нэгтгэн зохион байгуулахтай холбогдуулан зохих шийдвэрийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж, шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>Хууль зүйн үндэсний хүрээлэн, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнг нэгтгэн зохион байгуулж Улсын Их Хурлын дэргэд шилжүүлэн ажиллуулахаар энэхүү тогтоолоор шийдвэрлэсэн байна. Тогтоолын хэрэгжилтийг хангах асуудлыг судалж байна. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | | **УИХ-ын тогтоол: 11 тогтоолын 26 заалт.** | **100% - 12 заалт; 70% - 6 заалт; 0% - 1 заалт; ХБ – 7 заалт** | **Дундаж үнэлгээ: 85.3%** | |
| **Гурав. УИХ-ын Байнгын хорооны тогтоол** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | 69 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, № 15<br>ЭЗБХ<br>1.7/ Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалт, үр ашгийг сайжруулах үүднээс төрийн өмчийн хувьчлалыг үе шаттай, зохистой зохион байгуулах, ард иргэдэд үзүүлэх нийгмийн салбарын хүртээмж, үр өгөөжийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас 2023 онд “OECD ба Төрийн өмч, хувьчлал” сэдэвт хуралд УИХ, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөгчид оролцсон. Уг хурлын үеэр төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, төрийн өмчит компаниудын өмчлөлийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, өрсөлдөөнийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих, төрийн өмчит компаниудын комплайнсын асуудал зэрэг үндсэн асуудлаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, туршлага, цаашид хэрэгжүүлэхээр зорьж буй зорилтыг танилцуулсан. Мөн OECD-ээс 2015 онд гаргасан Төрийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалын талаарх зөвлөмжийн хэрэгжилт, түүнтэй уялдуулан гаргасан бусад зөвлөмж, гишүүн болон гишүүн бус орнуудад хийгдсэн техникийн туслалцаа, түүний зөвлөмжийн хэрэгжилтүүд мөн тус байгууллагаас OECD - Төрийн өмчит компанийн засаглалын талаарх дараагийн 2024 оны үндсэн зөвлөмжийн төслийг гишүүн болон ажиглагч орнуудад танилцуулан, санал солилцсон судалгаа шинжилгээтэй танилцан ажилласан. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 16 | 70 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №16<br>ЭЗБХ<br>2.4/.Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд арилжаалах, санхүүжилт босгохтой холбоотой үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. Энэ хүрээнд ТӨБЗГ нь 2022 оны “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулж байна.<br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна.<br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажлын хэсэг, Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн удирдлага, албан тушаалтнууд, авто замын засвар, арчлалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит 20 компанийн гүйцэтгэх захирлуудыг оролцуулсан авто | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 17 | 71 | | замын засвар арчлалтын 20 компанийн цаашдын төлөв байдлын талаар болон “Төрийн өмчит компанийн шинэчлэл болон нэмэлт хувьцаа “IPO” гаргах асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг, цахим уулзалтыг 2023 оны 01 дүгээр 23-ны өдөр зохион байгуулж, уулзалтын тэмдэглэлийг албажуулан Зам, тээврийн хөгжлийн сайдад хүргүүлсэн.<br><br>Мөн 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажлын хэсэг автозам засвар арчлалтын компаниудын болон “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн нэмэлт хувьцаа “IPO” гаргах талаар танилцуулга болон тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх санал зэргийг танилцуулсан. Үүний үр дүнд Засгийн газрын 244 дүгээр тогтоолд зохих өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br><br>“Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй компани болгох ажлын хүрээнд авто замын засвар, арчлалтын чиглэлээр ажилладаг төрийн өмчит 20 компанийг нэгтгэн “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, түүний энгийн хувьцааг нэмж гаргах, биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн 05 дугаар тэмдэглэл гаргасан бөгөөд холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр тогтсон.<br><br>“Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд нээлттэй худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-1/448 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 220 дугаар тогтоол гаргасан байна. | | |
| 17 | 71 | **Чиглэл өгөх тухай**<br><br>2018-05-02, № 10<br><br>ЭЗБХ<br><br>1.11/ Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргах, санхүүжилт босгохтой холбоотой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. Энэ хүрээнд ТӨБЗГ нь 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br><br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Мөн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд нээлттэй худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-1/448 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 220 дугаар тогтоол гаргасан байна.<br><br>Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Төрийн өмчийн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах, компанийн дүрмийг батлах, “Төрийн өмчийн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг тогтоох асуудлыг судлан боловсруулж, “Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Төрийн өмчийн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийн саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | | |
| 18 | 72 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br><br>2023-04-25, № 05<br><br>ТБХ<br><br>3а/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, **өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах**, **хэрэгжиж дууссан төслүүдийн хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах,** зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн муутай, хэрэгжилт | **ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨХШХ**<br><br>ТӨБЗГ-ын хуралдаанаар нийт зээл, хандив тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээг төрийн өмчид бүртгэх тухай асуудлыг хэлэлцэж, гаргасан 2023 онд 10 тогтоолоор нийт 84,939,788,645.93 (84.9 тэрбум) төгрөгийн хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэсэн байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах; | | | |
| | 73 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2023-04-25, № 05<br>ТБХ<br>4а/. төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын биет болон биет бус хөрөнгийг бүртгэх, хянах тогтолцоог сайжруулж, өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим систем бий болгох, нэгдсэн мэдээлэл, дүнг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод жил бүр танилцуулахтай холбоотой зохицуулалтыг хууль тогтоомжид оруулах санал бэлтгэх, танилцуулах; | **ТӨБЗГ – ТӨБАХ, ХЭЗХ**<br>Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын биет болон биет бус хөрөнгийг бүртгэх, хянах тогтолцоог сайжруулж, өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим систем бий болгох, нэгдсэн мэдээлэл, дүнг холбогдох байгууллагад мэдээлэх, танилцуулахтай холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Их Хуралд өргөн баригдаж, нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэгдэж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан болно.<br>2022 онд зохион байгуулсан төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод хөгжүүлэн ашигласан эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн системийг тодорхой түвшинд өргөжүүлж, зарим мэдээллийг нэмэх, боловсруулах, тухайлбал, хөрөнгийн орлого, зарлага, шилжилт хөдөлгөөн, их засвар, капиталжуулалт, данснаас хасах зэрэг үйлдлийг нэмж оруулан ашиглаж, 2022 оны улсын нэгдсэн статистикийн мэдээ тайланг гаргасан. Уг статистик мэдээнд төрийн болон орон нутгийн өмчит нийт 7113 хуулийн этгээдийн өмчийн талаарх захиргааны статистикийн мэдээ тайланг цахимаар авч нэгтгэн тусгасан. Нэгдсэн статистик мэдээг 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний Статистикийн хороонд medee@nso.mn цахим хаягаар хуулийн хугацаанд хүргүүлсэн. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| | 74 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2023-04-25, № 05<br>ТБХ<br>4б/. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтэц, орон тоо, зардлын зохистой байдлыг бий болгох, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын ил тод байдлыг хангах хүрээнд биржээр дамжуулан борлуулж, ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлэх, татварын дараах ашгийг хуваарилах, олон нийтийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. Энэ хүрээнд ТӨБЗГ нь 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн | “Хэрэгжих шатанд”— 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | оролцоог хангасан сайн засаглалтай болгох, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод болгох, тэдний эрх үүрэг, хүлээх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид нарийвчлан зохицуулах санал бэлтгэх, танилцуулах. | этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br>УИХ, ЗГ, ТӨБЗГ-ын тогтоолын хүрээнд компани тус бүрд нийт хувьцааны 34 хүртэлх хэмжээний нэмэлт хувьцааг гаргаж, биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон арилжихтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулах зэрэг асуудлыг Үнэт цаасны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг албан бичгээр хүргүүлсэн.<br>“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын төсөл, “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын төсөл, “Төрийн өмчит хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ын төсөл болон холбогдох танилцуулгыг боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/209 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг журмын төслүүдийг Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолоор тус тус баталсан. Уг журмуудыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн гүйцэтгэх захирал, захирлуудыг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтыг нийтэд нээлттэй ил тод мэдээлж ажилласан. “Цемент шохой” ТӨХК, “Дорноговь АЗЗА” ТӨХК, “Багануур АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК, “Говь-Алтай АЗЗА” ТӨХК, “Увс АЗЗА” ТӨХК, “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын гүйцэтгэх захирал, захирлуудыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилоод байна. | | |
| | 75 | **Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2023-04-25, № 05<br>ТБХ<br>6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ЗУХ**<br>Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр анхааран ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 19 | 76 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2023-06-11, № 03<br>ҮБХ<br>1.1/. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, мөн зах зээл дэх төрийн оролцоог багасгах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангаж засаглалыг сайжруулах зорилгоор хувьцааг нь олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. Энэ хүрээнд ТӨБЗГ нь 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Мөн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд нээлттэй худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-1/448 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 220 дугаар тогтоол гаргасан байна.<br>Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах (IPO гаргах) бэлтгэл хангах ажлын явцыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтмол танилцуулж ирсэн. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| | 77 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>2023-06-11, № 03<br>ҮБХ<br>1.2/. Хувьцаагаа нийтэд худалдсан төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй | “Хэрэгжих шатанд” - 70% | |

<table>
<tr><td></td><td></td><td>эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого’’-д нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлын хэрэгжилтийг хангах;</td><td>худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. Энэ хүрээнд ТӨБЗГ нь 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br><br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Мөн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд нээлттэй худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-1/448 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 220 дугаар тогтоол гаргасан байна.<br><br>Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах (IPO гаргах) бэлтгэл хангах ажлын явцыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтмол танилцуулж ирсэн.<br><br>Монгол Улсын Засгийн газраас явуулж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг тууштай хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 98 аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын хэмжээ өмнөх оноос 3.9 их наяд төгрөгөөр өсөж, 14.5 их наяд хүрсэн нь ДНБ-ний 27.5 хувьтай, төлсөн татварын хэмжээ 3.5 их наяд төгрөгт хүрсэн нь татварын нийт орлогын 22.7 хувьтай, ажиллагсдын тоо 56.9 мянгад хүрсэн нь нийт ажлын байрны 4.9 хувьтай тус тус тэнцэж байна.</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td>УИХ-ын Байнгын хорооны тогтоол:<br>5 тогтоолын 9 заалт</td><td>100% - 1 заалт; 70% - 8 заалт.</td><td colspan="2">Дундаж үнэлгээ: 73.3%</td></tr>
<tr><td colspan="6">Дөрөв. Ерөнхийлөгчийн зарлиг</td></tr>
<tr><td>20</td><td>78</td><td>Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай<br><br>2018-05-23, № 46</td><td>ТӨБЗГ – ЗУХ<br><br>Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, идэвх санаачилгыг өрнүүлэх талаар нийт албан</td><td>“Бүрэн хэрэгжсэн” - 100%</td><td></td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | хаагчдад мэдээлэн сурталчилж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн үзэл санааг дэмжин дэлгэрүүлэхэд анхааран ажиллаж байна.<br><br>Байгууллагын мэдээллийн самбарын зарим хэсгийг монгол, кирилл бичгээр хослуулан бичиж, сурталчлан таниулах ажлыг хийсэн. Байгууллагын өрөө, танхимын хаягжилтыг шинэчилж, монгол бичиг, кирилл үсгээр хослуулан бичиж байршуулав.<br><br>Мөн албан хаагчид аливаа мэдээллийг PPt танилцуулга хэлбэрээр бэлтгэхдээ байгууллагын нэрийг монгол бичиг, кирилл үсгээр хослуулан бичдэг болсон.<br><br>ТӨБЗГ-ын албан хаагчдын монгол бичгийн унших, бичих чадварыг сайжруулах зорилгоор "Бичиг Соёл" төвтэй 2022 оны 11 дүгээр сарын 15-ний өдөр "Монгол бичгийн сургалт зохион байгуулах гэрээ"-г байгуулсан. Сургалтын зардалд байгууллагын 2022 оны төсвөөс нийт 3.2 сая төгрөгийг зарцуулсан.<br><br>Энэхүү гэрээний дагуу сургалтыг 2023 оны 2 дугаар сараас эхлэх зохион байгуулж, байгууллагын нийт 35 албан хаагчийг 7 хоногт 3 удаагийн давтамжтайгаар 1 сарын хугацаанд нийт 30 цагийн монгол бичгийн сургалтад хамрууллаа. Амжилттай суралцаж, төгссөн албан хаагчдад "Бичиг Соёл" төвөөс гэрчилгээ олгосон байна. | | |
| 21 | 79 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай (Тэрбум мод)**<br><br>2021-10-04, № 58<br><br>2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ**<br><br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нийт албан хаагчид 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр СХД-ийн Баруун салаанд 2021 оны намар суулгасан 70 модоо арчилж, шинээр 30 мод нэмж тарьсан.<br><br>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 49 хуулийн этгээдтэй хамтран нийслэл 7 аймгийн 19 газарт 12 төрөл зүйлийн 4.0 сая гаруй модыг тарьж суулгаад байна. Цаашид "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих бэлтгэл хангах, үр суулгацын нөөцийг бүрдүүлэх чиглэлээр 2024 оныг хүртэл, тарьц суулгацыг шилжүүлэн суулгах ажлыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Байгууллагууд дэргэдээ хүлэмж байгуулж навчит модны 15.0 мянга, шилмүүст модны 160.0 мянга орчим модны тарьц бойжуулж байна.<br><br>Энэ ажил томоохон төрийн өмчит компани, үйлдвэрийн газрууд тухайлбал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ-ууд | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | идэвх санаачилгатай ажиллаж, өөрсдийн дэвшүүлсэн бүтээлч зорилтуудаа хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. | | |
| 22 | 80 | **Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай**<br>2022-07-11, № 159<br>2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах ажилд шаардлагатай төсвийг 2023 оны байгууллагын төсөвт тусгах арга хэмжээ авсан. Эш хөргийг 2023 оны сүүлийн хагас жилд тэмдэглэлт өдрөөр хүндлэн залахаар төлөвлөсөн. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” | |
| | 81 | **Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай**<br>2022-07-11, № 159<br>4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Ерөнхийлөгчийн зарлигийг албан хаагчдад таниулан сурталчилж, агуулга, үзэл санааг нь эрхэмлэн тунгааж, үйл хэрэгтээ тусган хэрэгжүүлэх, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн сургах талаар уриалгыг түгээсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | | **Ерөнхийлөгчийн зарлиг:**<br>**3 зарлигийн 4 заалт.** | **100% - 2 заалт; 70% - 1 заалт; ХБ – 1 заалт.** | **Дундаж үнэлгээ: 90.0%** | |
| **Тав. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 23 | 82 | **Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2021-04-07, № 89<br>3. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийг ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн “Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлэхээр тооцож, тус компанийн хөрөнгөд бүртгүүлэх арга хэмжээг авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Тавантолгой төмөр зам” ХХК нь “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв” төслийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс, баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан. ТЭЗҮ-д төлөвлөснөөр төсөл нь бутлуур, конвейерийн систем, овоолго үүсгэгч, овоолгоос тэжээгч, ачилтын бункер зэрэг дамжлага бүхий бүрэн автоматчлагдсан, цогц системээр дамжуулан жилд нийт 20.0 сая тонн нүүрсийг төмөр замд ачих хүчин чадалтай байх ба үүнээс Нүүрс баяжуулах үйлдвэрт 10.0 сая тонн нүүрсийг нийлүүлнэ.<br>Төслийн ажлын зураг төслийг Өмнөговь аймгийн Ерөнхий архитектур болон холбогдох яам, Тамгын газраар баталгаажуулж талбайн бэлтгэл ажил, бүтээн байгуулалтын ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 22-нд эхлүүлсэн. Төслийн нийт гүйцэтгэл 65.9 хувьтай байна. “Тавантолгой | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай. | төмөр зам” ХХК-ийн зүгээс төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2023 оны 4 дүгээр улиралд бүрэн дуусгаж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн.<br>Төсөлд нийт 313.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатайгаас ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, инженер геодезийн болон геологийн судалгаа хийх, БОННҮ боловсруулах, талбайн бэлтгэл ажлыг хангах болон үндсэн тоног төхөөрөмж захиалах зэрэг ажлуудад зориулж “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс нийт 169.7 тэрбум төгрөгийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д хуваарийн дагуу шилжүүлсэн. Энэ онд 25.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд цаашид үлдсэн санхүүжилтийг үе шаттай олгож ажиллана. | | |
| 24 | 83 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай**<br>2021-05-05, № 129<br>2. Энэ тогтоолын 1-д заасан үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр”, “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр” болон “Засвар, механикийн заводын өргөтгөл”-ийг тус тус “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх чиглэлээр: Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах HL-SX/EW технологиор боловсруулж, жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан гэрээний дагуу “Mining short long term” ХХК гүйцэтгэсэн. "Mining short long term" ХХК нь боловсруулсан ТЭЗҮ-ээ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлээд CTP/22-03-01 дүгээр дүгнэлтийг гаргуулсан байна. Уг ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, гэрээний салшгүй хэсэг болох техникийн даалгаврын дагуу болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 онд баталсан “Хүнд үйлдвэрийн салбарын техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба хүлээн авах журам”-д нийцүүлэн боловсруулах шаардлага үүссэн байна. Иймд дурдсан шаардлагын дагуу уг ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Техникийн зөвлөлөөр 2022 оны 11 дүгээр сарын 02-04-ний өдрүүдэд хэлэлцүүлсэн бөгөөд "Mining short long term" ХХК нь Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжийн дагуу ТЭЗҮ-ийг засварлан боловсруулж байна. Гэрээт ажлын хугацааг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан. ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, нарийвчилсан зураг төслийг шинэчлэн боловсруулна. Гүйцэтгэгч ТЭЗҮ-ийг засварлаж 2023.02.01-ний өдөр ирүүлснийг 2023.02.08-ны өдөр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээд дэмжсэн тул УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн баталгаажуулахыг гүйцэтгэгч компанид үүрэг болгосон. Тус ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр ойрын хугацаанд хэлэлцүүлж өгөхийг хүссэн 2023.02.17 (ТБ-69-12/704); | “Хэрэгжилт хангалтгүй” - 30% | Урт хугацаанд хэрэгжих төсөл. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2023.03.01 (ГЕ-69-12/842)-ний өдрийн албан бичгүүдийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас УУХҮ-ийн сайдад хүргүүлсэн байна. | | |
| | 84 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай**<br><br>2021-05-05, № 129<br><br>3. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газартай Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4-т заасны дагуу гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), **хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг хуульд заасан журмын дагуу төрийн өмчид бүртгэж авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т** тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br><br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосон. УУХҮЯ болон тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хооронд 2021 оны 5/159-21 дугаартай “ҮТП-ийн удирдлагатай байгуулах гэрээ” байгуулан ажиллаж байна.<br><br>Уул уурхай металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилгоор газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Орхон аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын одоо эзэмшиж буй 871.4 га, Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрээс 175.4 га, Жаргалант сумын нутаг дэвсгэрээс 170.6 га, нийт 1,217.4 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжиж, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Орхон аймгийн ИТХ-ын 14 дүгээр тогтоол гарсан болно.<br><br>Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр”, “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр” болон “Засвар, механикийн заводын өргөтгөл”-ийг тус тус “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж байгаа бөгөөд тус үйлдвэрүүд нь ашиглалтад ороогүй байгаа болно. Иймээс хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэх ажлын хугацаа болоогүй, хүлээгдэж байна. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Урт хугацаанд хэрэгжих төсөл. |
| 25 | 85 | **Хөрөнгө гаргах тухай**<br><br>2021-10-27, № 334<br><br>1. Замын-Үүдийн хилийн боомтын бүсийг ногоон бүс болгох зорилгоор “Замын-Үүд” чөлөөт бүсэд хилийн хяналтын байгууллагын албан хаагчид болон ачаа тээврийн жолооч нарыг тусгаарлан байрлуулах байр, сууц байгуулахад шаардагдах 948,248,000 (есөн зуун дөчин найман сая хоёр зуун дөчин найман мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>Замын-Үүдийн хилийн боомтын бүсийг ногоон бүс болгох зорилгоор “Замын-Үүд” чөлөөт бүсэд хилийн хяналтын байгууллагын албан хаагчид болон ачаа тээврийн жолооч нарыг тусгаарлан байрлуулах байр, сууц байгуулж, улсын комисс хүлээж авсны дараа шинээр бий болсон хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэнэ.<br><br>ТӨБЗГ-ын гүйцэтгэх ажлын хугацаа болоогүй, хүлээгдэж байна. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй”- ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг зохих журмын дагуу төрийн өмчид бүртгэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т нарт даалгасугай. | | | |
| 26 | 86 | **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хараат бус гишүүнийг томилох тухай**<br>2022-04-20, № 167<br>3. Компанийн бизнесийн стратегийг тодорхойлж, сайн засаглалын зарчмын дагуу удирдлагыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Компанийн тухай хууль болон бусад дүрэм журмын хүрээнд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хараат бус гишүүдийг сонгон шалгаруулалтыг өдөр тутмын хэвлэлээр нээлттэй зарлан тухайн компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүгнэлт гарган, шаардлага хангасан нэр дэвшигчийн материалыг Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэн шийдвэрлүүлж байна.<br>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь төлөөллийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллахад анхаарч, компанийн засаглалын зарчмыг баримтлан ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” - 70% | Энэ ямар компанитай холбоотой нь тодорхойгүй байгаа тул ерөнхий ойлголтын хүрээнд хэрэгжилтийг бичив.<br>Легалинфо эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2022 оны 167 дугаар тогтоол байхгүй, ТӨБЗГ-т энэ тогтоол ирээгүй, бүртгэгдээгүй. |
| 27 | 87 | **Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2022-05-25, № 203<br>2. Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах санал боловсруулж, 2022 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ, ТӨБАХ, ХЭЗХ**<br>ТӨБЗГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний үнэ тариф, зардлын норм, норматив болон Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишгийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан.<br>Энэ ажлын хүрээнд Бүгд Найрамдах Турк улс, Болгар, Казахстан, Хятад улсын төрийн захиргааны байгууллагын албан ажлын өрөө, тасалгааны нийтлэг жишиг, стандартын журмыг орчуулан судалсан.<br>Мөн яам, агентлагийн эзэмшилд байгаа албан конторын барилгуудын судалгаа, ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалтын судалгааг авч нэгтгэсэн. | “Хэрэгжилт хангалтгүй” - 30% | Зохион байгуулал-таас шалтгаалан удааширч байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Ажлын хэсэг нэгдсэн санал дүгнэлт гарган боловсруулж, 2023 оны 3 дугаар улиралд Засгийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | | |
| 28 | 88 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2022-05-25, № 204<br>3. Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Засгийн газрын 204 дүгээр тогтоолын дагуу 437 автомашиныг татан төвлөрүүлсэн. Тэдгээрийг Засгийн газрын автобааз болон бусад байршилд байршуулж хэрэгцээ шаардлагыг эрэмбэлсний үндсэн дээр дараах байдлаар шийдвэрлүүлсэн:<br>– Татан төвлөрүүлсэн автомашинаас зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байгууллага (ТХХ-ийн 6.5- цагдаа, онцгой, батлан хамгаалах, хүн эмнэлэг, мал эмнэлэг, шүүх, шүүхийн шийдвэр, хил, гааль зэрэг)-д нийт 85 автомашиныг балансаас баланст шилжүүлэх замаар шинэ автомашин худалдан авах төсвийг хэмнэсэн.<br>– Нийт 161 автомашиныг өдөр тутмын сонин, вэб сайтуудад байршуулах замаар ил тод мэдээлэн зарлаж, нээлттэй дуудлага худалдаагаар худалдан 888.0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>– Үлдэх өртөгтэй нийт 59 автомашиныг УИХ-ын тогтоолын төсөлд тусгаж, орон нутгийн өмчит эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад шилжүүлэх (ашиглалтын гэрээ байгуулах замаар)-ээр тогтсон.<br>– Үлдэх өртөггүй нийт 80 автомашиныг данснаас хасаж, засвар үйлчилгээ хийж сэргээх, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож орон нутгийн өмчид бүртгэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байна.<br>– “Засгийн газрын автобааз” ТӨҮГ-т 52 автомашин шилжүүлж, парк шинэчлэлт хийсэн.<br>Дээрх арга хэмжээний хүрээнд нийт 3.8 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан тооцоо байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Хяналтаас хасах саналтай байна. |
| | 89 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2022-05-25, № 204<br>4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Засгийн газрын автобааз” УТҮГ-ыг өөрчлөн зохион байгуулах, аймаг, нийслэл дэх автотээврийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, тухайн нутаг | **ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ**<br>Автомашин татан төвлөрүүлэх, үйлдлийн болон хяналтын шинэ дэвшилтэт техник, технологи, программ хангамж бүхий нэгдсэн системийг төрийн байгууллагын автомашины захиалга, дуудлагын нийтлэг үйлчилгээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэлгээний хороог байгуулан ажиллуулж, үйлчилгээний тодорхойлолт, хүрэх үр дүнг тодорхойлон боловсруулж, 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдөр тендер шалгаруулалтыг зарласан. Тендер шалгаруулалтыг 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр нээж, | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дэвсгэрийн болон автомашин, замын хөдөлгөөний зураглал, байршлын орон зайн мэдээллийг бүрэн хамруулсан үйлдлийн болон хяналтын шинэ дэвшилтэт техник, технологи, программ хангамж бүхий нэгдсэн системийг төрийн байгууллагын автомашины захиалга, дуудлагын нийтлэг үйлчилгээнд нэвтрүүлэн хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг шуурхай сонгон шалгаруулж хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Төрийн худалдан авах ажиллагааны газар (Х.Улам-Өрнөх)-т тус тус даалгасугай. | үнэлгээг тухайн өдөрт нь багтаан зохион байгуулсан бөгөөд үнэлгээний шатанд тодруулга, нэмэлт мэдээлэл авах шаардлага үүссэн. Тодруулгыг авч, 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр шалгарсан компанитай гэрээ байгуулах эрх олгосны дагуу “Хамтран ажиллах гэрээ” байгуулан туршилтаар ажиллуулсан бөгөөд туршилтын үр дүнгээр гэрээг үргэлжлүүлэхгүй байхаар шийдсэн байна.<br><br>Засгийн газрын 2022 оны 388 дугаар тогтоолоор “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрыг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, дүрмийг баталсан. Уг тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 538 дугаар тогтоолоор тус газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны дээд хязгаарыг баталсан. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 30 дугаар хуралдааны 32 дугаар тэмдэглэлээр “Засгийн газрын авто бааз” ТӨҮГ-ын захирлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, захирал томилогдох хүртэл хугацаанд захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилон ажиллуулж байна.<br><br>Автомашины дуудлагын үйлчилгээнд UB cab компани шалгарч, тухайн нутаг дэвсгэрийн болон автомашин, замын хөдөлгөөний зураглал, байршлын орон зайн мэдээллийг бүрэн хамруулсан үйлдлийн болон хяналтын шинэ дэвшилтэт техник, технологи, программ хангамж бүхий нэгдсэн системийг нэвтрүүлэх туршилт хийсэн. Туршилтын үр дүнгээр “Засгийн газрын автобааз” ТӨҮГ дээрх систем тохиромжгүй гэж үзэн түүнийг дахин ашиглахгүй байхаар шийдвэрлэсэн.<br><br>Автомашины дуудлагын үйлчилгээ үзүүлэх ажлыг “Засгийн газрын авто бааз” ТӨҮГ хариуцан ажиллаж байна. | | |
| | 90 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-05-25, № 204<br><br>5. Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний үнэ тариф, зардлын норм, нормативыг боловсруулж Сангийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар батлуулан мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ, ХЭЗХ**<br><br>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах журам”-ыг баталсан.<br><br>Журмыг мөрдөх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Чиглэл хүргүүлж, санал авах тухай” А-1/194 дүгээр албан бичгээр төрийн өмчит хуулийн этгээдүүдэд чиглэл хүргүүлж, журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулав. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 91 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2022-05-25, № 204<br>10. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, явц байдлыг шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ, ЗУХ**<br>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилогдон ажиллаж, тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахаас гадна шаардлагатай тухай бүрд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Засгийн газрын хуралдаанд танилцуулан ажиллаж байна.<br>Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Уг асуудлыг УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай асуудлыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн байна. УИХ-ын гишүүдийн зарчмын зөрүүтэй санал гарсантай холбоотой тогтоолын төслийг хууль тогтоомжийн санаачлагчид буцаасан тул УИХ-ын тогтоолын төслийг дахин өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна.<br>Мөн хяналтад авсан заалтын хэрэгжилтийн сар бүрийн явц, хагас, бүтэн жилийн тайлан мэдээллийг ЗГХЭГ-т тухай бүр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулан тайлагнан мэдээлж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| 29 | 92 | **Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай**<br>2022-05-31, № 220<br>1.1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан дараах зээлийн өр төлбөрийг барагдуулах дор дурдсан арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүн, хуулийн этгээдийн удирдлагад тус тус даалгасугай: 1.1. “Буянт-Ухаа-1”, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар “Төрийн орон сууцны корпорац” ХХК-д олгосон 142,693,633,474.83 (нэг зуун дөчин хоёр тэрбум зургаан зуун ерэн гурван сая зургаан зуун гучин гурван мянга дөрвөн зуун далан дөрвөн төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн зээлийн үндсэн төлбөр, гэрээний дагуу тооцсон үндсэн болон | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-д олгосон зээл, зээлийн хүүгийн төлбөрийн нийт дүнгээр үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авснаар дор дурдсан үр дүн гарсан.<br>Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Бүртгэлийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас ““Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн өрийн хэрэгслийг бүртгэх тухай” БХ22/77 дугаартай тогтоол гарсан. Улмаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК нь нийт 180.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий, 60 сарын хугацаатай, 8.5%-ийн хүүтэй бондыг гаргаж, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр анхдагч зах зээлийн арилжаа хийгдсэнээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1”, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар авсан зээл, түүний хүү болох нийт 185.65 тэрбум төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулсан.<br>Үнэт цаас гаргасантай холбоотойгоор Хөгжлийн банктай байгуулсан "Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ"-ний үүргийн | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлсэн хүүгийн нийт дүнд “Төрийн орон сууцны корпорац” ХХК-аас үнэт цаас гаргаж, Монгол Улсын Хөгжлийн банканд эзэмшүүлэх замаар зээлийн өрийг төлөх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Ганбат)-д; | гүйцэтгэлийг хангуулах зорилгоор “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн өмчлөлийн газар болон түрээсийн орон сууцны санд шилжсэн орон сууцнуудыг барьцаалсан бөгөөд барьцааны гэрээнүүдийг улсын бүртгэлд бүртгүүлэх ажиллагаа 99 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.<br>2023 оны 01 дүгээр сарын 11-нд Хөгжлийн банканд 5,328,800,000 төгрөгийн бондын хүүгийн төлбөрийг шилжүүлсэн байна. | | |
| | 93 | **Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай**<br>2022-05-31, № 220<br>3. Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлийн өр төлбөрийг хугацаанд нь төлөхгүй байгаа, зээлийг зориулалтын бусаар ашигласан зэргээр зээлийн гэрээ зөрчсөн зээлдэгчдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах, төрд учирсан хохирлыг нэхэмжилж барагдуулах, гэм буруутай этгээдэд холбогдох хуулийн хүрээнд хариуцлага хүлээлгэх талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Ганбат)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн нэр дээрх Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зээлийн өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/374, А96 дугаартай хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулагдан Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зээлийг балансаас балансат шилжүүлэх, тоног төхөөрөмжийн үнийг төсөвт тусгах тухай тогтоолын төслийг бэлтгэн баталгаажуулахаар ажиллаж байна.<br>Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд “Шинэ яармаг хаусинг прожект” ХХК-иас 24.6 тэрбум төгрөгийг гаргуулж “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-д олгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг 2022 онд дахин гаргаж, ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 183/Ш32022/14343 захирамжаар шүүхээс иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргасан. 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийж, хамтран ажиллах гэрээ”-г дүгнэж, дуусгавар болгох акт үйлдэн, Шүүхийн шийдвэрийн дагуу “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн хариуцан төлөх 24,604,103,971 төгрөгийг “Нью яармаг хаусинг прожект” ХХК нь үл хөдлөх хөрөнгөөр төлж барагдуулсан. Хөгжлийн банк дахь “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн нэр дээрх “Шинэ яармаг” төслийн зээлийн өр төлбөр төлөгдөж дууссан.<br>“МИАТ” ТӨХК-ийн BOEING767-300ER агаарын хөлгийг худалдан авах зориулалтаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн үлдэгдлийг 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр мөнгөн хэлбэрээр төлж барагдуулсан.<br>“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-аас “Хөтөл” ХХК-ийн авсан өр төлбөртэй холбоотой Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дээр Зээлийн гэрээний үүрэгт 389,055,659,842.00 төгрөгийг гаргуулах талаар хэрэг үүссэн байгаа бөгөөд тус хэрэгт хамтран | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хариуцагчаар “Цемент шохой” ТӨХК оролцож байна. Тус хэргийн оролцогчидтой холбоотой эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх, арбитрын журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг (“Бэйзмэнт” ХХК (“Хөтөл” ХХК)-ийн өв залгамжлагч нь Б.Тулга мөн эсэх асуудал тодорхой болох хүртэл), маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй үндэслэлээр түдгэлзсэн байна. Шүүх хурал 18 удаа хойшилсон ба одоогийн байдлаар дээрх шалтгааны улмаас түдгэлзсэн байна. | | |
| 30 | 94 | **“Эрдэнэс Монгол” нэгдлийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-06-08, № 225<br><br>2. “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа, стратеги болон бизнес төлөвлөгөө, тухайн жилийн зорилтот түвшний үзүүлэлт, хөрөнгө оруулалт, нийт үр ашгийг нэгдлийн хэмжээнд уялдуулан төлөвлөх саналаа боловсруулан энэ оны 8 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Энх-Амгалан)-д даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон “Монголросцветмет” ТӨҮГ-ыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд оруулахтай холбоотой энэхүү Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2019 оны 102, 103 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын дүрэмд Засгийн газрын 2022 оны 427, 428 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн. Уг дүрмийн өөрчлөлтөөр “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа, стратеги болон бизнес төлөвлөгөө, тухайн жилийн зорилтот түвшний үзүүлэлт, хөрөнгө оруулалт, нийт үр ашгийг нэгдлийн хэмжээнд уялдуулан төлөвлөх, батлах асуудлыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эрх хэмжээнд хамааруулан шийдвэрлэсэн. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулсан Засгийн газрын шийдвэр гарсан.<br><br>“Эрдэнэс Монгол” нэгдлийг группын зохион байгуулалтад оруулан зэс, металлын болон нүүрс, эрчим хүчний групп болгох холбогдох шийдвэрийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын үйл ажиллагаа, стратеги болон бизнес төлөвлөгөө, тухайн жилийн зорилтот түвшингийн үзүүлэлт, хөрөнгө оруулалт, нийт үр ашгийг нэгдлийн хэмжээнд уялдуулан төлөвлөх саналаа бэлтгэн Хувьцаа эзэмшигчид танилцуулсан. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 45 дугаар тогтоолоор “Нэгдлийн компани, хуулийн этгээдийг группийн зарчмаар ажиллуулах түр журам”-ыг батлан мөрдүүлж байна.<br><br>“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2022.12.20, 2022.12.28-ны өдрийн хурлуудаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2023 оны бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинг баталсан байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Шаардлагатай арга хэмжээг авч, нэгдлийн хэмжээнд тус үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг явуулж эхэлсэн, Засгийн газрын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн холбогдох шийдвэрүүд гарсан тул цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 31 | 95 | **Агаарын тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-06-22, № 238<br><br>4. “МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагааны менежментийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засаг, санхүүгийн бие даасан, тогтвортой байдлыг хангуулах арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “МИАТ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Мөнхтамир)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагаа менежментийг сайжруулах талаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:<br><br>1. 2022 оны навигацийн өглөгөөс чөлөөлүүлэх талаар ИНЕГ-тай холбогдох тооцоог хийж байна;<br>2. Франкфуртын нислэгийн татаас 4.7 тэрбум төгрөгийг 07 дугаар сарын 06-ны өдөр хүлээн авч, Монгол Улсын хөгжлийн банкны зээлийн төлбөрт 100 хувь шилжүүлсэн;<br>3. Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон агаарын тээврийн 4 тээвэрлэгч компанийн төлөөллийг оролцуулсан хамтарсан уулзалт зохион байгуулсан. 2023 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Монголбанк, арилжааны банкуудын хамтарсан “Зээлийн гэрээ”-г байгуулсан.<br><br>Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцүүлэн 365 дугаар тогтоолоор Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын 2 дахь заалтын “…иргэдийн төлөх зээлийн нийт хүүгийн 10.0 нэгж хүртэл хувийг,” гэсний дараа “хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээлийн нийт хүүгийн 7.0 нэгж хувийг” гэсэн агуулгаар нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлсэн.<br><br>Гуравласан гэрээний дагуу тээвэрлэгчид арилжааны банкуудаас зээл авах эрх нь үүссэн бөгөөд Голомт банк, Хаан банктай хийсэн гэрээний дагуу эргэлтийн хөрөнгийн болон дахин санхүүжилтийн нийт 45.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2023 оны 6 дугаар сард авсан болно. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| 32 | 96 | **Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай**<br><br>2022-06-29, № 244<br><br>3. Төрийн өмчит хуулийн этгээдийг олон нийтийн шууд хяналтад оруулах бодлогын хүрээнд энэ тогтоолын 1-д заасан хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, хувьцаа гаргах бэлтгэл хангах, биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгож, өөрчлөн байгуулах ажлыг | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. Энэ хүрээнд ТӨБЗГ нь 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, ажлын явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд тухай бүр нь танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br><br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Мөн авто замын засвар арчлалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниудын нэмэлт хувьцаа гаргах асуудлаар Засгийн газрын ажлын хэсэг, Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХХК-ийн удирдлагууд, төлөөлөл болон автозамын засвар арчлалтын 20 компанийн гүйцэтгэх удирдлагуудыг оролцуулсан цахим уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж, санал солилцлоо. Уг 20 компанийг нэгтгэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд нээлттэй худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-1/448 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 220 дугаар тогтоол гаргасан байна.<br><br>“Мэдээлэл, холбооны сүлжээ” ТӨХХК-ийн харилцаа холбооны салбарт эрхэлж буй үйл ажиллагааны онцлог, салбарын зохицуулалт, стратегийн ач холбогдол зэргийг харгалзан тус компанийг цаашид олон нийтийн хяналтад оруулах, нээлттэй компани болгох асуудлаар тухайн салбарын хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br><br>Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах (IPO гаргах)-д бэлтгэл хангах ажлын явцыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтмол танилцуулж ирсэн. | | |
| 33 | 97 | **Агентлаг байгуулах тухай**<br><br>2022-07-05, № 272<br><br>5. “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын орон тоо, техник хэрэгсэл, | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Ойн газрыг байгуулж, татан буулгасан “Ойн судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгө, авлага, өр төлбөрийг шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг БОАЖ-ын сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны | “Хэрэгжиж шатанд” - 70% | Хэрэгжилт удааширч байгаа нь ТӨБЗГ-аас шалтгаа-лаагүй. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тоног төхөөрөмж зэрэг эд хөрөнгө, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газрын чиг үүрэг, орон тоо, цалингийн сан, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг Ойн газарт тус тус шилжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | өдрийн А/450 дугаар тушаалаар байгуулагдсан. Тус ажлын хэсэг хөрөнгийг газар дээр нь үзэж, хяналтын тооллого хийсэн.<br>“Ойн судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгө, авлага, өглөгийн тооцоог баталгаажуулан шилжүүлэх ажиллагаа үргэлжилж байна. БОАЖЯ-наас байгуулсан Ажлын хэсэг хуралдаагүй, үйл ажиллагаа зогсонги байдалтай байгаа болно. | | |
| 34 | 98 | **Төрийн өмчийн зарим боловсролын сургалтын байгууллагын талаар авах арга хэмжээний тухай**<br>2022-08-03, № 293<br>8. Энэ тогтоолын 6-д заасан үйлдвэрийн газар байгуулагдсантай холбогдуулан өмнө байсан ижил төстэй үйл ажиллагаатай байгууллагын орон тоо, өмч хөрөнгийг тус үйлдвэрийн газарт балансаас балансt шилжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 684 дүгээр тогтоолоор Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны хөрөнгөд бүртгэлтэй, 45 нэрийн нийт 766.2 тэрбум төгрөгийн балансын үнэ, 747.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Их, дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансt шилжүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 35 | 99 | **Төрийн өмчит зарим үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай**<br>2022-08-24, № 317<br>4. “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн батлахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. 4. “Геологийн судалгааны төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, “Геологийн төв лаборатори” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>“Геологийн судалгаа-шинжилгээний төв” ААТТӨҮГ-ын захирал, ерөнхий геологи, ерөнхий инженерийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/274 дүгээр тушаалаар байгуулан ажиллуулав. Уг ажлын хэсэг үйлдвэрийн газрын захирлыг нээлттэй сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн мэдээллийг УУХҮЯ-ны 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/3407 дугаар албан бичгээр ТӨБЗГ-т ирүүлсэн. Тус саналыг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар нэр дэвшигч Д.Мөнхбаатарыг томилж, ажлын хэсэг томилон үүрэгт ажлыг 2023 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хүлээлгэн өгсөн. Мөн ТӨБЗГ-ын 2023 оны 5 дугаар | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | журмын дагуу “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт шилжүүлэх, данс, бүртгэлд тусгуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | тогтоолоор тус байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг баталсан.<br><br>ТӨБЗГ-ын даргын 2023 А/8 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллуулсан. ТӨБЗГ-ын 2023 оны 20 дугаар тогтоолоор “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 14,942,178,574.49 төгрөгийн балансын үнэ, 5,491,164,849.66 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 5,784,639,866.65 төгрөгийн үнэ бүхий эргэлтийн хөрөнгө, өр төлбөрийг “Геологийн судалгаа-шинжилгээний төв” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас балансt шилжүүлсэн. ТӨБЗГ-ын 2023 оны 21 дүгээр тогтоолоор “Геологийн судалгааны төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 2,835,043,069.41 төгрөгийн балансын үнэ, 1,176,884,805.26 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгө, 1,017,403,189.83 төгрөгийн үнэ бүхий хөрөнгө, өр төлбөрийг “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас балансt шилжүүлсэн. | | |
| 36 | 100 | **“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-09-22, № 353<br><br>1. Эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай ажиллагааг хангах, цахилгаан, эрчим хүчний хязгаарлалт хийхээс урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагыг харгалзан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5-д заасныг баримтлан “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн гэмтсэн трансформаторыг шуурхай солих арга хэмжээ авч, өвлийн их ачааллын үе эхлэхээс өмнө ашиглалтад оруулахыг тус компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Станцын найдвартай ажиллагааг хангах, өвлийн их ачааллыг амжилттай давах ажлын хүрээнд ОХУ-ын Воронёж хотын SIEMENS компанитай “Гэмтсэн трансформаторын ороомгийг сольж засварлах, шинэ трансформатор худалдан авах гэрээ”-г хийсэн. Гэрээний дагуу гэмтсэн трансформаторыг засварласан, шинээр худалдан авсан трансформаторыг 2022 оны 12 дугаар сард суурилуулсан бөгөөд хэвийн ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 37 | 101 | **Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-10-05, № 362<br><br>2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий **төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилох эрх бүхий этгээд, Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгаж,** орон нутгийн өмч давамгайлсан эрх бүхий этгээдэд зөвлөсүгэй.<br><br>2.1.Засгийн газрын шийдвэргүйгээр төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ бүх төрлийн шинэ гэрээ байгуулахыг зогсоох; 2.2. Төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ болон төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээний дагуу, эсхүл төлбөр нь нэн даруй хийгдэх ашигт малтмалын экспортыг валютын бодит орох урсгалыг нэмэгдүүлэхээр оновчтой зохион байгуулах; 2.3. Ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой албаны болон байгууллагын нууцад хамааралтай гэрээ, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2022 оны 11 дүгээр сард багтаан нууцаас гаргаж, ил тод болгох арга хэмжээ авах, цаашид нууц гэрээ байгуулахгүй байх. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Тогтоолын заалтаар өгсөн үүрэг, чиглэлийг харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд мөрдөн хэрэгжүүлэх талаар анхааран ажиллаж, хэрэгжилтийг хангуулж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 102 | **Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-10-05, № 362<br><br>3. Хүчин төгөлдөр гэрээ, хэлцлүүдийн хүрээнд экспорт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх ажлыг компани бүр төлөвлөгөөтэй зохион байгуулж байна.<br><br>"Монголросцветмет" ТӨҮГ гэхэд 2023 оны 6 дугаар сарын байдлаар Монголбанкинд 21.96 сая ам.долларыг худалдаад байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | оновчтой зохион байгуулах замаар 2022 оны 4 дүгээр улиралд багтаан “Эрдэнэс Тавантолгой” ХК 500.0 сая ам.доллар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 300.0 сая ам.доллар, “Монголросцветмет” ТӨҮГ 20.0 сая ам.доллар, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨҮГ 15.0 сая ам.доллароос багагүй орлогыг тус тус төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Энх-Амгалан), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Г.Ёндон), “Монголросцветмет” ХХК (Б.Мөнхбат), “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК (А.Ариунболд)-нд тус тус үүрэг болгосугай. | “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 15.1 сая ам. долларын орлого төвлөрүүлсэн мэдээлэлтэй байна. | | |
| 38 | 103 | **Төр, засгийн нийтлэг үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-11-09, № 400<br><br>2. Татан буугдсан төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын эд хөрөнгөд тооллого хийж, хаалтын баланс гаргах, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газарт шилжүүлэх, бүртгэх болон өр төлбөрийг барагдуулах, чөлөөлөгдсөн ажилтнуудад тэтгэмж олгох зэрэг хууль тогтоомжид заасан арга хэмжээг зохион байгуулах комисс томилон ажиллуулах талаар зохих арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>Тогтоолыг хэрэгжүүлэхээр Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2022 оны 85 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:<br><br>– “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ыг татан буулгаж, ТӨБЗГ-ын 2022 оны 723 дугаар тогтоолоор нийт 537.9 сая төгрөгийн хөрөнгийг Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газарт;<br>– “Төрийн ордны мэдээлэл үйлчилгээний цогцолбор” ТӨҮГ-ыг татан буулгаж, ТӨБЗГ-ын 2023 оны 140 дүгээр тогтоолоор нийт 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газарт;<br>– “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй нийт 66.6 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалыг Хил хамгаалах ерөнхий газарт;<br>– “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 117.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий авлага болон хөрөнгийг Төр засгийн үйлчилгээ эрхлэх газарт<br><br>тус тус балансаас балансt шилжүүлж, жилийн эцсийн болон хаалтын санхүүгийн тайланд тусгуулснаар хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг дуусгавар болгосон. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| 39 | 104 | **Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨБАХ** | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | ТӨБЗГ-аас гүйцэтгэх ажил |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2022-11-23, № 417<br><br>2. 2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т тус тус даалгасугай: **2.1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах Комиссыг байгуулж, удирдлагаар хангаж ажиллах, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дуусгалтын тайланг гаргуулан, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг зохих журмын дагуу шийдвэрлэх;** 2.2. аймаг, нийслэлийн хэмжээнд Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан дэд комиссыг байгуулж, аймаг, нийслэл дэх мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгах, чиг үүрэг, орон тоог шилжүүлэх ажлыг зохион байгуулах; 2.3. мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг орон тоо, төсөв, ашиглаж буй компьютер техник, хэрэгслийн хамт одоо эрхэлж байгаа чиг үүрэг, мэргэжлийн чиглэлийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д заасан байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах; 2.4. энэ тогтоолын 2.3-т заасан улсын байцаагчаас бусад албан хаагчийг тэргүүн ээлжид ажлын байраар хангах чиглэлийг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих; **2.5. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын балансt бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх**. | ЗГХЭГ-ын даргын 2022 оны 89 дүгээр тушаалаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгах комисс болон холбогдох дэд комиссуудыг байгуулсан.<br><br>Мэргэжлийн хяналтын байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх хөрөнгийг яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжин ажиллаж байгаа албан хаагчдын ашиглаж байсан техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглалтын картын бүртгэлээр хүлээлцүүлж, хариуцуулсан.<br><br>Мэргэжлийн хяналтын 19 байгууллагын нийт 11.7 тэрбум төгрөгийн 10032 нэрийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2023 оны 114, 115, 116, 117, 118, 119, 120, 121, 122, 123, 124, 125, 126, 127, 128, 129, 130, 131, 132 дугаартай тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдүүдэд балансаас балансt шилжүүлсэн.<br><br>Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбоотой орон нутгийн өмчит нийт 19 хуулийн этгээдэд 1.8 тэрбум төгрөгийн 2714 нэрийн хөрөнгийг шилжүүлэх асуудлыг УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төсөлд тусган Засгийн газарт хүргүүлсэн. Засгийн газраас уг асуудлыг УИХ-д өргөн мэдүүлсний дагуу УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд ажлын хэсэг томилогдон ажилласан бөгөөд Эдийн засгийн Байнгын хорооны болон Чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан (2023.03.23). УИХ-ын гишүүдийн зарчмын зөрүүтэй санал гарсантай холбоотой тогтоолын төслийг хууль тогтоомжийн санаачлагчид буцаасан тул УИХ-ын тогтоолын төслийг дахин өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна. Шийдвэр гарах хүртэл МХЕГ, түүний салбаруудад бүртгэлтэй бөгөөд орон нутгийн өмчид шилжүүлэх хөрөнгийг ашиглалтын гэрээгээр хүлээлгэн өгсөн болно.<br><br>Татан буулгах комиссын саналын дагуу үл хөдлөх хөрөнгө балансаас балансt шилжүүлэх асуудлыг ТӨБЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 03 дугаар тэмдэглэлээр дэмжин Засгийн газрын шийдвэр гаргуулахаар ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын 109 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгууд дахь Мэргэжлийн хяналтын газруудын хөрөнгөд бүртгэлтэй нийт 19.6 тэрбум төгрөгийн барилга байгууламж (газар эзэмших эрх)-ийг төрийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэхээр тогтож, шийдвэрлэсэн.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний “Албан томилолтоор ажиллуулах тухай” А/42 | | хийгдсэн тул бүрэн хэрэгжсэн гэж үзэн хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | дугаар тушаалын дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээг дүгнэх, татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансdefinitely шилжүүлэх тухай” Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох байгууллагуудад үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг шилжүүлэх, байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагын асуудлыг судлан, санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023.06.05-25-ны өдрүүдэд 21 аймагт ажиллаж, дээрх шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг хэрэгжүүлэв. | | |
| 40 | 105 | **Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2022-11-23, № 419<br>5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, зохих салбар нэгжтэй төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудад боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэхдээ Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ажиллах асуудлыг бодлогоор дэмжиж, төвлөрлийг сааруулах, орон нутгийн хөгжлийг түргэтгэх хүрээнд үе шаттай үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх чиглэл өгсөн. Энэ хүрээнд уг асуудалтай холбоотой тооцоо судалгааг хийлгэн 2023 оны бизнес төлөвлөгөөнд нь үе шаттай тусгуулж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байна. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| 41 | 106 | **“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай**<br>2022-11-30, № 434<br>2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ**<br>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 94 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/ТТЗ-ЗБТ дугаар удирдамжийн дагуу “Тавантолгой-Зүүнбаян”, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл, “Богдхан” төмөр замын төслийн хэрэгжилт болон “Зүүнбаян төмөр зам” ХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажилласан. Удирдамжийн дагуу ажлын хэсэг 2 хуваагдан холбогдох чиглэлээр хийсэн хяналт шалгалт хийсэн.<br>Ажлын хэсгийн ажил үүргийн хуваарийн дагуу “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын төслийн үндсэн 3 гүйцэтгэгчийн нэг болох “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн туслан гүйцэтгэгчтэй холбоотой | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | баримт бичиг, материалд хийсэн хяналт шалгалтын тайланг боловсруулан дэд ажлын хэсгийн тайланд нэгтгүүлэхээр хүргүүлсэн. Ажлын хэсэг нэгдсэн тайланг боловсруулж байна. | | |
| 42 | 107 | **“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-11-30, № 435<br><br>2. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Монголын төмөр зам” ТӨХК хэрэгжүүлэхээр тогтоосугай. 2. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой галт тэрэг, ачаа тээвэр, зүтгүүр, вагоны цогц программын шаардлагатай төсвийн зардлыг хөрөнгө оруулалтын төсөвт тусган батлуулсан.<br><br>Тус цогц программын техникийн шаардлагыг боловсруулж, программын шаардлагыг гаргасан. Галт тэрэгний хөдөлгөөн хянах систем нь Тавантолгой төмөр замын хэмжээнд өртөөний болон хоорондын замд зорчиж буй галт тэрэгний хөдөлгөөн, ачааны ажиллагаанд (салбар зам, терминал) болон ачаа тээвэр, техникийн гэмтлээр саатан зогссон вагонуудын төрөл, байрлал гэх мэт хүчин зүйлүүдээр өртөөний паркийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, өртөөдийг шуурхай үнэн зөв мэдээллээр хангана. Түүнчлэн, галт тэрэгний хөдөлгөөнийг төлөвлөх, вагоны гүйлт, вагоны техникийн үйлчилгээ, засварт орсон тухай мэдээлэл, үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан, тээврийн төлөвлөгөөт үзүүлэлтүүд (ачааны нэг ажиллагаан дахь вагоны сул зогсолт, орон нутгийн вагоны сул зогсолт, зүтгүүрийн бүтээмж гэх мэт)-ийг биелүүлэх, вагоны байршлыг тодорхойлж ачаа хүргэх хугацааг биелүүлэх зэрэг төмөр замын тээврийн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах олон талын үүрэг гүйцэтгэх юм.<br><br>Тээвэрлэлтийн ажлыг оновчтой зөв зохион байгуулах, технологи ажиллагааг мөрдөж ажиллах чиглэлээр өртөөдийн технологийн бичиг баримтад өөрчлөлт оруулж батлан мөрдүүлээд байна. Тавантолгой өртөө, Цогтцэций өртөө хооронд галт тэрэг солилцох түр журмыг өөрчлөх саналыг боловсруулан "Монголын төмөр зам" ТӨХК-ийн холбогдох албанд хүргүүлсэн. Хамтарсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, хоёр талаас саналуудаа тусган батлуулахаар бэлтгэж байна. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэлээр хатуу тооцоот багаж хэрэгслийг тогтмол шалгаж, хяналт тавьж байна. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| | 108 | **“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-11-30, № 435 | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 94 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д тус тус даалгасугай. | баталсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/ТТЗ-ЗБТ дугаар удирдамжийн дагуу “Тавантолгой-Зүүнбаян”, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл, “Богдхан” төмөр замын төслийн хэрэгжилт болон “Зүүнбаян төмөр зам” ХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажиллаж байна. Удирдамжийн дагуу ажлын хэсэг 2 хуваагдан холбогдох чиглэлээр хяналт шалгалт хийсэн.<br><br>Ажлын хэсгийн ажил үүргийн хуваарийн дагуу “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын төслийн үндсэн 3 гүйцэтгэгчийн нэг болох “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн туслан гүйцэтгэгчтэй холбоотой баримт бичиг, материалд хийсэн хяналт шалгалтын тайланг боловсруулан дэд ажлын хэсгийн тайланд нэгтгүүлэхээр хүргүүлсэн. Ажлын хэсэг нэгдсэн тайланг боловсруулж байна. | | |
| | 109 | **“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-11-30, № 435<br><br>4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Ж.Ганбат)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлыг санхүүжүүлэх гэрээ хүчин төгөлдөр байгаа ба гэрээний дагуу үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| | 110 | **“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-11-30, № 435<br><br>5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ, дүрэмд өөрчлөлт оруулах, бүтэц, зохион байгуулалтыг зохих журмын дагуу шинэчлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Засгийн газрын 2022 оны 435 дугаар тогтоолоор Компанийн төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх эрх өөрчлөгдсөнтэй холбоотой компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2023 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 01/24 дүгээр албан бичгийн дагуу өөрчлөлтийн саналын төслийг боловсруулан 2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1/64 дүгээр албан бичгээр ЗТХЯ, 1/65 дугаар албан бичгээр “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус хүргүүлсэн. ЗТХЯ-ны 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2023 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн албан бичгээр | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай. | тус тус ирүүлсэн саналыг тусган дүрмийн төслийг эцэслэн боловсруулж байна.<br><br>Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 1/149 дүгээр албан бичгээр “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд санал авахаар хүргүүлсэн. 2023.05.01-ний өдрийн байдлаар хариу ирүүлээгүй байна.<br><br>“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн шинэчилсэн бүтцийн төслийг 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт танилцуулсан бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулагдахаар хүлээгдэж байна. | | |
| | 111 | **“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-11-30, № 435<br><br>6. Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтоор шинээр баригдах хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, хэрхэн санхүүжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Уг ажлын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, нарийвчилсан судалгааны ажилд шаардлагатай хөрөнгийн дүнг "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оын 02 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын төмөр замын ТЭЗҮ-ийг I улиралд багтаан дуусгах, барилгын ажлыг II улиралд эхлүүлэх зорилгоор ТЭЗҮ, зураг төслийн гүйцэтгэгч болох Хятадын талын санал болгосон Зураг төслийн 3-р товчоотой гэрээ байгуулах, эрх авах тогтоолын төслийг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2023 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 1/09 дугаар албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Засгийн газрын 2 дугаар сарын 01-ний хуралдаанаар хэлэлцэх байсан нь тодорхойгүй хугацаагаар хойшилсон.<br><br>Мөн “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 1/104 тоот албан бичгээр Ерөнхий сайдын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 35 дугаар захирамжаар байгуулагдсан Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр зам, шилжүүлэн ачих байгууламжийг цогцоор нь барих ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулахаар захирамжийн төслийг боловсруулан ЗТХЯ-нд хүргүүлсэн. Ингэснээр Хил холболтын асуудлыг хариуцсан ажлын хэсгийн дарга Боомтын сайд болох юм.<br><br>Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлэхээр БНХАУ-ын талаас үнийн санал ирүүлсэн. Үнийн саналын дагуу үнэ бууруулах чиглэлээр 2023 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс 2023 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн хооронд хэлэлцээ хийсэн. Мөн Хятадын “Чайна энержи”, “Боашин төмөр | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зам", "Хятадын төмөр замын зураг төслийн корпорац"-ийн төлөөлөгчид 2023 оны энэ 2 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсад ажлын айлчлал хийж, ЗТХЯ, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, төлөөлөгчидтэй уулзав. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын ТЭЗҮ-ийн инженерийн шийдлийн асуудал, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчтэй санамж бичиг, урьдчилсан төлөвлөгөөний талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогттой уулзалтууд хийгдсэн.<br>БЭТ-ийн 2023 оны А/12 тоот тушаалаар "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан холболтын төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулах" Зөвлөх үйлчилгээг үзүүлэх Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. Нээлттэй тендер зарлаж, тендерийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр нээсэн. 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн дотор гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>2023 оны 04-р сарын 23-ны өдрийн байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд ачаатай 50 галт тэрэг аялуулж, 40,776.0 тн., Тавантолгой-Цогтцэций чиглэлд ачаатай 160 галт тэрэг аялуулж, 206,991.0 тн. ачаа тээвэрлэсэн. Галт тэрэгний хөдөлгөөнийг оновчтой зөв зохион байгуулж, хөдөлгөөний аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллаж байна. | | |
| 43 | 112 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2022-12-07, № 448<br>1.20.төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшлийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 1 хувиар тооцсон дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашиг тооцон хуваарилж төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; 1.21.төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ, МТА**<br>1.20. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу улсын төсөвт 570.1 тэрбум төгрөгийн орлогыг төрийн өмчид ногдох ногдол ашгаас болон төрийн өмчийн түрээсийн орлогоос төвлөрүүлэх үүрэг хүлээж байна. Үүнээс Ирээдүйн өв санд 540.1 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийг төвлөрүүлнэ. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх ногдол ашгийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор тогтоов. Уг тогтоолоор 2022 онд нийт дүнгээр 126.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 20 хуулийн этгээд 2023 онд улсын төсөвт нийт 59.7 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашиг, ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч 3 хуулийн этгээдийн | "Бүрэн хэрэгжсэн" - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулах арга хэмжээг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулж, улирал бүр дүгнэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; 1.22.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгож өөрчлөх, хувийн хэвшлийн зонхилох байр суурийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц судалгаа хийж, бодлогын чиглэлийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т. | нийт 1.9 их наяд төгрөгийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд 552.0 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийг төвлөрүүлэхээр хувь, хэмжээг тогтоосон байна.<br>1.21. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан мэдээллийг тухай бүр нь цахим хуудсандаа байршуулах чиглэлийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аван ажиллаж байна. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл зэргийг ашиглан олон нийтэд ил тод болгох, энэ талаарх тайлан мэдээг хариуцан ажиллах албан хаагчийг тодорхой болгуулж, хамтран ажиллаж байна.<br>1.22. УИХ-ын үйлдвэржилтийн Байнгын хорооноос Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд худалдах үндсэн чиглэл”-д өөрчлөлт оруулах асуудлыг судлан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтад Засгийн газрын 2023 оны 54 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан болно. | | |
| | 113 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2022-12-07, № 448<br>2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2023 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ уг хуульд тусгагдан батлагдаагүй болно. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” | Цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS- www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | | | |
| | 114 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-12-07, № 448<br><br>3. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг холбогдох яам, агентлагт шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн албан хаагчийг зохих албан тушаалд хуваарилан томилох, бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдөх албан хаагчид хуульд заасан тэтгэмж олгохыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, **эд хөрөнгийг шийдвэрлэх талаар санал боловсруулж,** танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>ЗГХЭГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 89 дүгээр тушаалаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгах комисс болон холбогдох дэд комиссуудыг байгуулсан.<br><br>Мэргэжлийн хяналтын байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх хөрөнгийг яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжин ажиллаж байгаа албан хаагчдын ашиглаж байсан техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглалтын картын бүртгэлээр хүлээлцүүлж, хариуцуулсан.<br><br>Мэргэжлийн хяналтын 19 байгууллагын нийт 11.7 тэрбум төгрөгийн 10032 нэрийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2023 оны 114, 115, 116, 117, 118, 119, 120, 121, 122, 123, 124, 125, 126, 127, 128, 129, 130, 131, 132 дугаар тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдүүдэд балансаас балансt шилжүүлсэн.<br><br>Татан буулгах комиссын саналын дагуу үл хөдлөх хөрөнгө балансаас балансt шилжүүлэх асуудлыг ТӨБЗГ-ын 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 03 дугаар тэмдэглэлээр дэмжин, Засгийн газрын шийдвэр гаргуулахаар ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br><br>Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж, 109 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгууд дахь Мэргэжлийн хяналтын газруудын хөрөнгөд бүртгэлтэй нийт 19.6 тэрбум төгрөгийн барилга байгууламж (газар | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | эзэмших эрх)-ийг төрийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний “Албан томилолтоор ажиллуулах тухай” А/42 дугаар тушаалын дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээг дүгнэх, татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансt шилжүүлэх тухай” Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох байгууллагуудад үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг шилжүүлэх, байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагын асуудлыг судлан, санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023.06.05-25-ны өдрүүдэд 21 аймагт ажиллаж, дээрх шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг хэрэгжүүлэв. | | |
| 44 | 115 | **“Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-12-09, № 450<br><br>3.5. компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ**<br><br>Энэ тогтоолын дагуу зохион байгуулсан 2 удаагийн ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажилласан байна.<br><br>1. Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хамтарсан Ажлын хэсэг байгуулагдан удирдамжийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн тус компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд иж бүрэн хяналт шалгалтын ажлыг хийсэн.<br><br>Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд хийх санхүүгийн хяналт шалгалтын удирдамж, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын даргын баталсан ажлын төлөвлөгөөний дагуу дараах чиглэлээр хяналт шалгалт хийв:<br>– Эрх бүхий байгууллагаас өмнө хийгдсэн хяналт шалгалт, аудитын тогтоол, шийдвэр, акт, зөвлөмжийн хэрэгжилт;<br>– Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 345 дугаар тогтоолын хэрэгжилт;<br>– Байгууллалтын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, газар болон компанийн биет болон биет бус хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний талаар;<br>– Компанийн засаглал, бүтэц зохион байгуулалт зэрэг асуудал болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Шалгалтын ажил батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу явагдсан бөгөөд тайланг нэгтгэн ажлын хэсэгт хүргүүлж баталгаажуулсан.<br><br>2. Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн СХЭУГ/01 дугаартай удирдамжийн дагуу “Тавантолгой” ХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 45 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.<br><br>ТӨБЗГ-аас томилогдон ажилласан ажлын хэсгийн гишүүний шалгалтын дүнгээр тус компанид мөрдөж буй хууль, тогтоомжийг зөрчиж компанийн ТУЗ-ийн гишүүдэд илүү олгосон цалин, урамшуулал, орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр, хяналтын тооллогоор дутагдсан үндсэн хөрөнгө, ТУЗ-ийн тогтоол шийдвэрийг зөрчин хөрөнгө илүү акталсан, төрийн хэмнэлтийн хууль тогтоомж зөрчин үргүй зардал гаргасан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээг сонгон шалгаруулалтгүй хэрэгжүүлсэн зэрэг нийт 170 гаруй тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд шалгалтын тайланг ажлын хэсгийн нэгдсэн тайлан, дүгнэлтэд нэгтгүүлсэн болно. | | |
| 45 | 116 | **“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2022-12-12, № 459<br><br>3.4. “Богдхан” төмөр зам төсөл болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Төрийн худалдах авах ажиллагааны газар (Ц.Батзул) нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 94 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/ТТЗ-ЗБТ дугаар удирдамжийн дагуу “Тавантолгой-Зүүнбаян”, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл, “Богдхан” төмөр замын төслийн хэрэгжилт болон “Зүүнбаян төмөр зам” ХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажиллаж байна. Удирдамжийн дагуу ажлын хэсэг 2 хуваагдан холбогдох чиглэлээр хийсэн хяналт шалгалтын тайланг нэгтгэх үйл ажиллагааг гүйцэтгэж байна. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| 46 | 117 | **Орон сууц хувьчлах тухай**<br><br>2022-12-28, Дугаар 482<br><br>2. Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Баянгол дүүргийн 6 дугаар хороо, 10 дугаар хороололд байрлах 73 | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Гаалийн ерөнхий газрын дансанд бүртгэлтэй 20 айлын орон сууцны 18-ыг нь төлбөргүй, 2-ыг нь үнэ төлбөртэй хувьчлахаар шийдвэрлэсний дагуу ТӨБЗГ-аас “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр бүртгэн баталгаажуулж олгов. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дугаар байр (20 айл)-ны 1 дүгээр хавсралтад заасан 18 орон сууцыг нь үнэ төлбөргүй, 2 дугаар хавсралтад заасан 2 орон сууцыг үнэ төлбөртэйгөөр одоо амьдарч байгаа иргэн, албан хаагчдад нь тус тус хувьчилсугай. 2.Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үнэ төлбөртэйгөөр хувьчилсан орон сууцны төлбөрийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | Засгийн газрын тогтоолоор тухайн 2 орон сууцанд одоо оршин сууж байгаа 2 иргэнд үнэ төлбөртэй хувьчлахаар шийдвэрлэсний дагуу тус тухайн иргэдээс төрийн өмчийн өмч хувьчлалын орлогын дансанд төлбөрөө шилжүүлсэн тул мөн “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгосон. | | |
| 47 | 118 | **Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай**<br>2022-12-28, Дугаар 488<br>5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны батлагдсан төсөвт багтаан нийт 54 албан хаагчийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо https://hrm.csc.gov.mn цахим системд бүртгэн оруулсан байна.<br>Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоосонтой холбогдуулан ТӨБЗГ-ын даргын 2023 оны Б/10 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин дээр 20 хувийн нэмэгдлийг тооцон олгох асуудлыг шийдвэрлэсэн. Уг шийдвэрийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна. ТӨБЗГ нь төрийн үйлчилгээний нийт 11 орон тоотой бөгөөд, тэдгээрт үндсэн цалингаас тооцон 20 хувийн нэмэгдэл, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны болон бусад нэмэгдлүүдийг олгож байна.<br>Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол хүчингүй болсон бөгөөд төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөхөөр болж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн бөгөөд дараачийн шийдвэр гарч, энэ тогтоол хүчингүй болсон тул хяналтаас хасах саналтай. |
| 48 | 119 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2023-02-08, № 50<br>2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Энэ тогтоолоор “Монголросцветмет” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 айлын орон сууцыг тус үйлдвэрийн газарт 29 жил тасралтгүй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ба 2020 оны 09 дүгээр сараас тус үйлдвэрийн газрын эзэмшлийн Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны 16 хороолол Апартмент-5 хотхоны 52/9 байрны 78 тоот байранд оршин сууж байгаа ахмад настан Д.Баярсайханд, 45 жил тасралтгүй ажилласан Гавьяат уурхайчин Я.Сүхбат агсны эхнэр Д.Нинад 2020 оны 09 дүгээр сараас тус үйлдвэрийн газрын эзэмшлийн | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны 16 хороололд Апартмент-5 хотхоны 52/9 байрны 81 тоот байранд оршин сууж байгаа орон сууцыг нь, мөн тус үйлдвэрийн газарт 25 жил тасралтгүй ажилласан Б.Баяр агсны эхнэр А.Даваад 1982 оноос тус үйлдвэрийн газрын эзэмшлийн Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны 18 дугаар байрны 11 тоотод оршин сууж байгаа орон сууцыг нь тус тус үнэ төлбөргүй хувьчлахаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу ТӨБЗГ-ын даргын шийдвэрээр 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 25, 26, 27 дугаартай "Орон сууц эзэмших эрхийн бичиг"-ийг тус 3 иргэнд гардуулж өгсөн. | | |
| 49 | 120 | **Үл хөдлөх эд хөрөнгө нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тухай**<br>2023-02-08, № 51<br>2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг шинэчлэн хийлгэсний үндсэн дээр нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгын зах зээлийн өнөөгийн үнэ цэнийг үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний эрх бүхий байгууллага болох “Капитал зууч” ХХК-иар шинэчлэн үнэлүүлж, 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 1/331 дүгээр албан бичгээр үнэлгээний тайлан болон дуудлага худалдааны доод үнийн саналыг компаниас авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцүүлсэн. Хэлэлцсэн асуудалтай холбоотой “Үл хөдлөх эд хөрөнгө нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тухай” 319 дүгээр тогтоол гаргав. Нээлттэй дуудлага худалдааны зарыг Өдрийн сонин, тухайн компанийн болон ТӨБЗГ-ын газрын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбараар нийтэд ил тод зарласан. Дуудлага худалдаа 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдана. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| 50 | 121 | **Үл хөдлөх эд хөрөнгө балансаас балансит шилжүүлэх тухай**<br>2023-02-08, № 52<br>2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үл хөдлөх хөрөнгийг балансаас балансит шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах хүрээнд холбогдох байгууллагад чиглэл өгч ажилласан байна. Холбогдох байгууллагаас балансын дүнг санхүүгийн тайланд тусгасан талаарх хэрэгжилтийн тайланг ирүүлэх хугацаа болоогүй байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 51 | 122 | **Үл хөдлөх эд хөрөнгө балансаас балансит шилжүүлэх тухай**<br>2023-02-08, № 53 | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах хүрээнд холбогдох байгууллагад чиглэл өгч ажилласан байна. Холбогдох | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үл хөдлөх хөрөнгийг балансаас балансt шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай | байгууллагаас балансын дүнг санхүүгийн тайланд тусгасан талаарх хэрэгжилтийн тайланг ирүүлэх хугацаа болоогүй байна. | | |
| 52 | 123 | **Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2023-02-08, Дугаар 68<br>3. Татан буугдсан мэргэжлийн хяналтын байгууллагын эзэмшлийн зарим аймаг дахь газрыг орон нутагт шилжин суурьшсан иргэдэд зориулсан орон сууцны барилга барих, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зориулалтаар шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Ханх сумын 3 дугаар багт байрлах 8000 м.кв газрын “Эзэмших эрх”-ийг тус аймгийн Ханх суман дахь Гаалийн хороонд шилжүүлэх асуудлыг Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Уг шийдвэрээр тухайн газрыг орон нутагт шилжин суурьшсан иргэдийн орон сууцны барилга барих зориулалтаар эзэмшүүлэхээр тогтсон. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| 53 | 124 | **“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2023-03-01, № 82<br>5. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрчимжүүлэхийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогтод, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төслийн явц, тулгамдсан асуудлуудыг Монгол Улсын ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Ажлын албаны дарга Д.Ариунболд тэргүүтэй албаны хүмүүст 3-р сард танилцуулж, 2023 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн ҮАБЗ-ийн хуралдаанд тус компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг танилцуулга хийсэн бөгөөд уг хуралдаанаас Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудаас шалтгаалж буй хүндрэлтэй асуудлуудыг яаралтай шийдвэрлэх үүрэг чиглэлийг Засгийн газрын гишүүд болон холбогдох албаны хүмүүст өгсөн.<br>Мөн УИХ-ын Үйлдвэржилтийн Бодлогын Байнгын Хорооны 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанд Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн бүтээн байгуулалтын явц, тулгамдаж буй асуудлуудыг танилцуулсан бөгөөд тус хорооноос тогтоол гаргаж, Засгийн газарт тодорхой чиглэлийг өгсөн байна.<br>“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Засгийн газрын 2023 оны 82 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийг тогтоож, “Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд тус компанийг ажиллуулж байгаа тул | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй”-ХБ. | ТӨБЗГ-т хамаарах-гүй, тухайн заалтаар тус байгуул-лагад даалгасан үүрэг байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | энэ тогтоол болон тухайн заалтын хэрэгжилт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамаарахгүй байна. | | |
| 54 | 125 | **Журам батлах тухай**<br><br>2023-03-07, № 85<br><br>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг журамд нийцүүлэх, холбогдох дүрэмд тусган батлуулж, мөрдүүлэх арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулан хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг энэхүү тогтоолоор баталсан бөгөөд уг журмыг мөрдөж ажиллах талаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад чиглэл хүргүүлсэн.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг уг журмын дагуу сонгон шалгаруулж, хууль тогтоомжийн дагуу нэр дэвшүүлэх асуудлаар компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж өгсөн. Төрийн өмчит 17 компанийн нийт 8 Төлөөлөн удирдах зөвлөл (зарим компаниуд дундаа нэг ТУЗ-тэй)-өөс хараат бус гишүүнээр томилуулахаар холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтын үр дүнд нэр дэвшүүлсэн нийт 15 нэр дэвшигчийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 175 дугаар тогтоолоор 2023 оны 06 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн томилсон байна. Уг тогтоолоор тэдгээр Төлөөлөн удирдах зөвлөлд 14 хараат бус гишүүн улиран томилогдож, 15 хараат бус гишүүн чөлөөлөгдсөн.<br><br>Түүнчлэн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллав. Эрчим хүчний сайдын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А-72 дугаар тушаалаар Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат 26 компанийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулав. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/39, А/40, А/41 дүгээр тушаалаар Зам, тээврийн салбар, Мэдээлэл, харилцаа холбооны салбар, Барилга, хот байгуулалтын салбарын төрийн өмчит хувьцаат 27 компанийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулав. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн, цаашид хэрэгжилт тогтмолжин хэвших боломжтой тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 55 | 126 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансt шилжүүлэх тухай**<br>2023-03-15, № 93<br>2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансt шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>“МИАТ” ТӨХК-ийн балансt бүртгэлтэй, 17 нэрийн нийт 6,004,168,044.52 төгрөгийн балансын үнэ, 462,339,127.31 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 59,648 м.кв талбай бүхий газар эзэмших эрх, барилга байгууламжийг Иргэний нисэхийн ерөнхий газарт балансаас балансt шилжүүлсэнтэй холбоотой холбогдох байгууллагуудад чиглэл өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Холбогдох байгууллагуудаас хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланд тусгасан талаарх хэрэгжилтийн мэдээллийг ирүүлэх хугацаа болоогүй байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 56 | 127 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансt шилжүүлэх тухай**<br>2023-03-15, № 94<br>2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансt шилжүүлэх, өр авлагыг тооцоо нийлж, хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Энэ тогтоолоор “МИАТ” ТӨХК-ийн балансt бүртгэлтэй, нийт 1,224,568,102.46 төгрөгийн балансын үнэ, 51,014,641.76 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 9046 м.кв талбайтай газар эзэмших эрх, агуулахын барилгуудыг нийт 1,224,568,102.46 төгрөгийн төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т балансаас балансt шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор холбогдох байгууллагуудад чиглэл өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Холбогдох байгууллагуудаас хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланд тусгасан талаарх хэрэгжилтийн мэдээллийг ирүүлэх хугацаа болоогүй байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 57 | 128 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансt шилжүүлэх тухай**<br>2023-03-29, № 109<br>2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансt шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний “Албан томилолтоор ажиллуулах тухай” А/42 дугаар тушаалын дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээг дүгнэх, татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансt шилжүүлэх тухай” Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох байгууллагуудад үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг шилжүүлэх, байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагын асуудлыг судлан, санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023.06.05-25-ны өдрүүдэд 21 аймагт ажиллаж, тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг хэрэгжүүлэв. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 58 | 129 | **Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2023-05-03, № 160 | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"МИАТ" ТӨХК нь “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-тай холбоотой НӨАТ-ын хуримтлагдсан өр төлбөрийн талаар 2023 оны 5 дугаар сарын 23-нд Татварын Ерөнхий Газар болон ИНҮТ, бусад агаарын тээвэрлэгч | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.5. “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-д дотоодын агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК, “Хүннү Эйр” ХХК, “Аэро Монголиа” ХХК-аас төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын хуримтлагдсан өрийг барагдуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т | байгууллагын төлөөлөл бүхий хамтарсан уулзалтад удирдлагуудын түвшинд оролцсон ба холбогдох байгууллагын удирдлагуудад тус асуудлын талаарх танилцуулга, мэдээлэл хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн байна. Мөн тус асуудлыг шийдвэрлэж өгөх талаар Татварын Ерөнхий газрын Нэмэгдсэн өртгийн албан татварын хэлтэст 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн албан бичгийг хүргүүлсэн. Татварын ерөнхий газраас хариу хүлээж байна. | | |
| 59 | 130 | **Орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг үйлдэх зарим арга хэмжээний тухай**<br>2023-05-24, № 201<br>3. “МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагааны ашгаас 2023 онд улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг төрийн өмчит бусад хуулийн этгээдээс төвлөрүүлсэн орлогын давсан хэсгээс нөхөх арга хэмжээ авах, цаашид тус компанийн 2024-2026 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусган төлөвлөж, хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"МИАТ" ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 01/2144 дүгээр албан бичгээр ногдол ашиг төлөхөөс чөлөөлж өгөхийг хүссэн хүсэлтийг харгалзан Засгийн газрын энэхүү тогтоолын заалтыг хэрэгжүүлэх үндэслэлээр “МИАТ” ТӨХК-ийн 2022 оны үйл ажиллагааны ашгаас 2023 онд улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг бусад хуулийн этгээдээс төвлөрүүлэх орлогын давсан хэсгээс нөхөх арга хэмжээ авч, тус компанийг улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогоос чөлөөлөв. Уг асуудлыг ТӨБЗГ-ын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор шийдвэрлэв. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Зохион байгуу-лалтын арга хэмжээ авч, хэрэгжил-тийг хангасан тул хяналтаас хасуулах саналтай. |
| 60 | 131 | **Арьс, ширний талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2023-02-08, № 65<br>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан боловсруулаагүй бүх төрлийн арьс, ширийг Хөдөө аж ахуйн биржээр бүртгэлжүүлэн, дэл, сүүлгүйгээр арилжих ажлыг зохион байгуулахыг Хөдөө аж ахуйн бирж (О.Нарандэлгэр)-д, биржээр арилжсан арьс, ширийг экспортлох үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т тус тус үүрэг болгосугай | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Боловсруулаагүй бүх төрлийн арьс шир”-ийг 2023 оны 1-р сарын 01-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд экспортод гаргахыг зөвшөөрсөн бөгөөд Хөдөө аж ахуйн биржээр боловсруулаагүй бүх төрлийн арьс, ширийг бүртгэлжүүлэн дэл, сүүлгүйгээр арилжих ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосон. Энэ ажлын хүрээнд 2200 ширхэг боловсруулаагүй үхрийн ширийг биржээр арилжаалан экспортод гаргаад байна.<br>Уг тогтоол болон тухайн заалт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамааралгүй бөгөөд тус байгууллагад даалгасан үүрэг байхгүй байна. | Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй – ХБ. | ТӨБЗГ-т хамаарах-гүй, тухайн заалтаар тус байгуул-лагад даалгасан үүрэг байхгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай. |
| | | **ЗГТогтоол: 38 шийдвэрийн 50 заалт** | **100% - 24 заалт; 70% - 19 заалт; 30% - 2 заалт; ХБ – 5 заалт;** | **Дундаж үнэлгээ: 84.2%** | |

| Зургаа. Ерөнхий сайдын захирамж | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 61 | 131 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br><br>2023-02-06, Дугаар 28<br><br>2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааны чиглэл, салбар, хүрээг оновчтой тогтоож, өмчлөл, засаглалын зохистой бодлогыг хэрэгжүүлэх, бүтээмж, үр ашгийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний цогц санал боловсруулан танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Арга хэмжээний цогц саналаа шуурхай боловсруулан танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Амарбаясгалан)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн харьяанд ажиллуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2019 оны 102, 103 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын дүрэмд Засгийн газрын 2022 оны 427, 428 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.<br><br>“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой дулааны станц” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд мөн ажиллуулахаар шийдвэрлэсэн. “Эрдэнэс Монгол” нэгдлийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байхаар тогтоосон.<br><br>“Эрдэнэс Монгол” нэгдэлд хамааруулснаас бусад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг “Төрийн өмчийн корпорац” ТӨХХК-д харьяалуулан нэгтгэх ажлын хүрээнд эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын бүтцийг оновчтой болгох, үр ашгийг дээшлүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нэгтгэх, Авто зам засвар, арчлалтын төрийн өмчит компаниудыг нийлүүлэн зохион байгуулснаар одоогийн байгаа 80 хуулийн этгээдийг 35 болгох саналыг боловсруулан ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br><br>Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нэгдмэл удирдлагын тогтолцоо бий болох, төрийн өмчит компаниудын засаглал сайжрах, улсын томоохон бүтээн байгуулалтад хөрөнгө оруулах, төрийн өмчит компаниудаас төвлөрсөн ашгийг ард иргэдэд хүртээмжтэй тэгш хүргэх боломжийг бүрдүүлэх, салбарын компаниудыг нэгтгэн санхүү, эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулж, дотоодын хөрөнгийн зах зээлд гаргах боломж бүрдэж, дотоодын хөрөнгийн зах зээл хөгжинө гэж үзсэн. Мөн төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа илүү ил тод болж, олон нийт нэгдсэн нэг платформоос шаардлагатай мэдээллийг тогтмол шуурхай хүлээн авах, олон нийт мэдээлэлд ойр болсноор хяналт, сахилга бат сайжрах, хөрөнгийн оновчтой менежмент хийх, хөрөнгө оруулалтын зохистой нөхцөл бүрдэж, технологийн шинэчлэл хийгдэх зэрэг олон давуу талууд бий болно гэж үзсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 62 | 133 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>2023-05-22, № 93<br>2. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, үр ашиггүй зардлыг бууруулах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн нэгдсэн тооллогын ажлыг зохион байгуулж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Хуульд заасны дагуу болон бусад эрх бүхий этгээдийн шийдвэрээр үүсгэн байгуулагдсан, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд (компани тэдгээрийн охин, хараат компани, сан, үйлдвэрийн газар)-ийн тоо, дүнг нэгтгэн 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, үр ашиггүй зардлыг бууруулах ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд (компани тэдгээрийн охин, хараат компани, сан, үйлдвэрийн газар)-ийн тоо, дүнг нэгтгэж, мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны А-1/1185 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| | | **Ерөнхий сайдын захирамж: 2 шийдвэрийн 2 заалт.** | **100% - 1 заалт.** | **Дундаж үнэлгээ: 100%** | |
| **Долоо. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 63 | 134 | **“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай**<br>2021-02-24, № 13<br>XI.2.1. “Төрийн орон сууцны корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах замаар төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагууд болон “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн төлөөлөл оролцсон бүрэлдэхүүн 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Сандагсүрэн болон бусад холбогдох албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулж, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар ярилцсан.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А-1/534 дүгээр албан бичгээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазарт уг асуудлаар хамтран ажиллах тухай хүсэлт хүргүүлсэн.<br>“Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК нь шинээр байгуулагдах байгууллагын дүрэм, байгууллагын бүтэц бүрэлдэхүүний талаар | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | даалгав: 1. “Төрийн орон сууцны корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах асуудлыг нарийвчлан судалж, санал солилцож нэгдсэн байр сууринд хүрэх талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалантай хамтран зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; | Барилга, хот байгуулалтын яамтай хамтран тодорхой саналуудыг гаргаад байна.<br><br>“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийг татан буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар шийдвэрлэсэн байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэн зохих шийдвэр гаргана. Өнөөдрийг хүртэл Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ямар нэгэн шийдвэр гаргаагүй байгаа болно. | | |
| | 135 | **“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай**<br><br>2021-02-24, № 13<br><br>XI.2.2. “Төрийн орон сууцны корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах замаар “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах асуудлыг холбогдох компаниудын хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах, хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг боловсруулж, хувь эзэмшигчийн хэмжээ, шинээр байгуулах компанийн хөрөнгийн хэмжээ зэргийг нэг мөр тооцож, зохих шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг орон сууцжуулахтай холбогдсон зорилт, арга хэмжээг “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон компанийн дүрмийн төсөлд тусгах асуудалтай холбоотой санал боловсруулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазарт хүргүүлсэн.<br><br>“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийг татан буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар шийдвэрлэсэн байна.<br><br>Тайлбар: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэж, зохих шийдвэр гаргана. | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; | | | |
| | 136 | **“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай**<br><br>2021-02-24, № 13<br><br>XI.2.3. “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани шинээр байгуулахтай холбогдуулан “Төрийн орон сууцны корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, шилжүүлэх, өр төлбөрийг хэрхэн барагдуулах талаар судалж, шийдвэрлүүлэх талаар тодорхой саналаа холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулан хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (С.Наранцогт)-д; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын 2022 оны А/374, А96 дугаартай хамтарсан ажлын хэсэг байгуулагдан “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн нэр дээрх хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зээлийг балансаас балансt шилжүүлэх, тоног төхөөрөмжийн үнийг төсөвт тусгах тухай тогтоолын төслийг бэлтгэн баталгаажуулахаар ажиллаж байна.<br><br>2. “Шинэ яармаг хаусинг прожект” ХХК-иас 24.6 тэрбум төгрөгийг гаргуулж "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК-д олгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг 2022 онд дахин гаргаж, ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 183/ШЗ2022/14343 захирамжаар иргэний хэрэг үүсгэсэн. 2022.12.30-ны өдөр “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийж, хамтран ажиллах гэрээ”-г дүгнэж, дуусгавар болгох акт үйлдэн, Шүүхийн шийдвэрийн дагуу "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК-ийн хариуцан төлөх 24,604,103,971 төгрөгийг “Нью яармаг хаусинг прожект” ХХК нь үл хөдлөх хөрөнгөөр төлж барагдуулсан. Хөгжлийн банк дахь "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК-ийн нэр дээрх “Шинэ яармаг” төслийн зээлийн өр төлбөр төлөгдөж дууссан.<br><br>3. Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын 1.1-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч, Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-д олгосон зээл, зээлийн хүүгийн төлбөрийн нийт дүнгээр үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулсан. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Бүртгэлийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас ““Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн өрийн хэрэгслийг бүртгэх тухай” БХ22/77 дугаартай тогтоол гарсан. Улмаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК нь нийт 180.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий, 60 сарын хугацаатай, 8.5%-ийн хүүтэй бондыг гаргаж, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр анхдагч зах зээлийн арилжаа хийгдсэнээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1”, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар авсан зээл, түүний хүү болох нийт 185.65 тэрбум төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулсан.<br><br>Үнэт цаас гаргасантай холбоотойгоор Хөгжлийн банктай байгуулсан "Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ"-ний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор “Төрийн орон сууцны корпорац” | “Бүрэн биелсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ТӨХХК-ийн өмчлөлийн газар болон түрээсийн орон сууцны санд шилжсэн орон сууцнуудыг барьцаалсан бөгөөд барьцааны гэрээнүүдийг улсын бүртгэлд бүртгүүлэх ажиллагаа 99 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.<br><br>2023 оны 01 дүгээр сарын 11-нд Хөгжлийн банканд 5,328,800,000 төгрөгийн бондын хүүгийн төлбөрийг шилжүүлсэн байна. | | |
| | 137 | **2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл**<br><br>2021-02-24, № 13<br><br>XI.2.4. “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулахтай холбогдуулан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг орон сууцжуулахтай холбогдсон зорилт, арга хэмжээг компанийн дүрэмд хэрхэн тусгаж, уялдуулах саналаа танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт.” | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг орон сууцжуулахтай холбогдсон зорилт, арга хэмжээг “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон компанийн дүрмийн төсөлд тусгах асуудалтай холбоотой санал боловсруулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазарт хүргүүлсэн.<br><br>“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийг татан буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар шийдвэрлэсэн байна.<br><br>Тайлбар: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэж, зохих шийдвэр гаргана. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| 64 | 138 | **Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн өмчлөлийн хэлбэр, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, компанийн засаглал, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br><br>2021-03-10, № 17 | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ**<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг хэт ерөнхий болон давхцал, хийдэлтэй зохицуулсны улмаас хяналт хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүнд тавих хяналтыг сулруулж, үр өгөөжгүй захиран зарцуулах үр дагаварт хүргэж байна. Иймээс, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор уг | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | XII.2.1. Төрийн өмчит үйлдвэрийн газар, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн өмчлөлийн хэлбэр, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, компанийн засаглал, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: **1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн үндэслэл, зохицуулах харилцааны давхардал, зөрчлийг арилгах, өмчийн тухай ойлголтыг эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан шинээр тодорхойлох, өмчийн удирдлагыг боловсронгуй болгох, өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх зүйн үндсийг тодорхой болгох, холбогдох хуулиудын уялдаа холбоог хангах судалгаа хийж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг** Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | асуудлыг шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудлыг тусгасан.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн ЗГ-1/146 дугаартай албан бичгээр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцээд Үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн.<br><br>Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар уг хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх анхны хэлэлцүүлэгт бэлтгэх, Эдийн засгийн Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Ажлын хэсэг зохион байгуулалтын талаар тохиролцож, өгсөн үүрэг, чиглэлийн дагуу холбогдох материал, судалгаа, дүгнэлтийг боловсруулах чиглэлээр ажиллаж байна. | | |
| 65 | 139 | **XҮ.7. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын исэлдсэн хүдрийн болон тодорхой нөхцөлд үр ашигтай буюу ядуу агуулгатай хүдрийн овоолгын ашиглалтын тухай**<br><br>2021-10-13, № 55<br><br>“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын исэлдсэн хүдрийн болон тодорхой нөхцөлд үр ашигтай буюу ядуу агуулгатай хүдрийн овоолгыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үндэслэл, хүдрийн нөөцөд тулгуурлан одоогийн нөхцөлөөс илүү үр ашигтай нөхцөлөөр ашиглах санал | **ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Овоолгын одоогийн ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна.<br><br>Ажлын хэсэг нь **“**Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг исэлдсэн хүдрийн болон тодорхой нөхцөлд үр ашигтай буюу ядуу агуулгатай хүдрийн овоолгын ашиглалтын байдал, цаашид авах арга хэмжээний талаарх санал боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 21 дүгээр тэмдэглэл гаргасан болно. | “Бүрэн биелсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | боловсруулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэлд даалгав. | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг исэлдсэн хүдрийн болон тодорхой нөхцөлд үр ашигтай буюу ядуу агуулгатай хүдрийн овоолгын ашиглалтын байдал, хамтран ажиллах саналаа ирүүлсэн компаниудын төлөөлөлтэй хийсэн уулзалтын дүгнэлт, үр ашгийн судалгаа тооцоололд үндэслэн Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, танилцуулгын хамт ЗГХЭГ-т ТӨБЗГ-ын 2022 оны А-1/1113 дугаар албан бичгээр хүргүүлсэн болно. | | |
| 66 | 140 | **Ү. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br><br>2021-11-10, № 59<br><br>1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.<br><br>2.Энэ тогтоолын 1, 2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагатай холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нарт тус тус даалгав. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 345 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн ашигт ажиллагаа, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах, төрийн өмчийн өгөөжийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” асуудлыг ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, 675 дугаар тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгчид, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал нарт холбогдох үүрэг даалгавар зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажилласан.<br><br>ТӨБЗГ-аас хувьцаа эзэмшигчийн 100 хувийн эрхийг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал нартай байгуулсан 2021 оны гэрээг 2022 онд үзүүлэлт бүрээр дүгнэн дүгнэлт гаргаж, “Хангалтгүй” дүгнэгдсэн хуулийн этгээдийн удирдлагуудтай байгуулсан гэрээг цуцлах, 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах талаар тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд Төрийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа гишүүдэд удирдамж, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулсан байна.<br><br>Гүйцэтгэх захирал болон захирал нартай байгуулсан 2022 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан журам, аргачлалын дагуу дүгнэхээр удирдамж, чиглэл өгсөн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлж буй 41 хуулийн этгээдийн 2022 оны эдийн засгийн | “Бүрэн биелсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хянан санал дүгнэлт боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллуулав. Ажлын хэсэг уг асуудлыг хэлэлцэн санал дүгнэлт гаргаж, ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулахаар бэлтгэсэн. Харин Эрчим хүчний салбарын компаниудын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Дээрх ажлын дүн болон аудитаар баталгаажсан 2022 оны санхүүгийн тайлангийн дүнгийн нэгтгэлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 87 хуулийн этгээд нийт дүнгээр 14,553,979.9 сая төгрөгийн орлого олж, 11,561,950.2 сая төгрөгийн зардал гаргаж, 2,055,798.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. | | |
| 67 | 141 | **XIII.9. В.И.Лениний нэрэмжит клубын барилга, газар эзэмшлийн тухай**<br>2021-11-17, № 60<br>ҮIII.9. В.И.Лениний нэрэмжит клубын барилга, түүний эзэмшилд хамаарах газрын улсын тусгай хэрэгцээнд авах боломжтой эсэхийг судлан үзэх, үүний зэрэгцээ уг газраас бусдад эзэмшүүлэх, ашиглуулахаар олгосон шийдвэрийг цуцлах талаар холбогдох иргэн, хуулийн этгээдтэй яриа хэлэлцээ хийх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>“Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах ОХУ-ын эдэлбэр газар болон үл хөдлөх хөрөнгө (Ленин клуб)-ийн эрхийг дахин бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронды хэлэлцээр”-ийн төслийг эцэслэж тохиролцсон.<br>Хэлэлцээрийг хийж ОХУ-ын талтай ойлголцолд хүрсэн. Газар олгосон шийдвэрийг цуцлах асуудал нь Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд хамаарах асуудал бөгөөд хэлэлцээр батлагдсаны дараа шийдвэрлэхээр хүлээгдэж байна. Одоо дипломат шугамаар ноот солилцох, соёрхон батлуулах ажлыг Гадаад харилцааны яам хариуцан гүйцэтгэнэ. | “Хэрэгжих шатанд” – 70% | ТӨБЗГ-аас хамаарах хэлэлцээр хийх ажил хийгдсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 68 | 142 | **Тэмдэглэл**<br>2021-11-24, № 61<br>XI.4.7. Хилийн Шивээхүрэн-Сэхээ боомтын хилийн төмөр замын боомтын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх асуудлаар хятадын талтай яриа, хэлэлцээ хийхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт;<br>“Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийг татан буулгах эсэх, “Монголын төмөр зам” ТӨХК болон “Өсөх зоос” ХХК-ийн хамтарсан компани | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Зам, тээврийн хөгжлийн яам, “Монголын төмөр зам” ТӨХК болон “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийн төлөөлөл оролцсон уулзалтаар “Шивээхүрэн-Сэхээ” хилийн боомтын төмөр замыг барих асуудлаар санал солилцож, Засгийн газрын 2018 оны 232 тоот тогтоолын дагуу хэрэгжүүлэх талаар хамтарсан компани байгуулах саналыг “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийн төлөөллөөс гаргасан. Иймээс “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийг татан буулгах эсэх, “Монголын төмөр зам” ТӨХК болон “Өсөх зоос” ХХК-ийн хамтарсан компани байгуулах эсэх асуудлаар өнөөг хүртэл Засгийн газраас ямар нэгэн шийдвэр гараагүй байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгуулах эсэх асуудлыг судалж 2021 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат БНХАУ-ын Хөгжил Шинэтгэлийн Хороотой цахим уулзалт хийж, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтын төмөр замын танилцуулгыг хийсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлээр Шивээхүрэн-Сэхээ боомтын төмөр замын урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусган, холбогдох баримт бичгийг Хятадын талд хүргүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК-д үүрэг болгосны дагуу ажлын хэсэг байгуулагдан ТЭЗҮ-ийг боловсруулж байна. | | |
| 69 | 143 | **Тэмдэглэл**<br>2022-02-09, № 9<br>IY.1. Монгол Улсын Хөгжлийн банкнаас төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор зээл авсан төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, холбогдох төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>1. Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын 1.1-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч, Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-д олгосон зээл, зээлийн хүүгийн төлбөрийн нийт дүнгээр үнэт цаас гаргах асуудлыг шийдвэрлэсэн. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Бүртгэлийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн өрийн хэрэгслийг бүртгэх тухай” БХ22/77 дугаартай тогтоол гарсан. 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 180.5 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж, анхдагч зах зээлийн арилжаа хийгдсэнээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Буянт-Ухаа-1”, “Буянт-Ухаа-2” төслийг санхүүжүүлэх зориулалтаар авсан зээл, түүний хүү болох нийт өр төлбөрийг төлж барагдуулан, Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>2. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд “Шинэ яармаг хаусинг прожект” ХХК-иас 24.6 тэрбум төгрөгийг гаргуулж “Төрийн орон сууц” ТӨХХК-д олгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг 2022 онд дахин гаргаж ХУД-ын Иргэний анхан шатны шүүхийн 2022 оны 183/Ш32022/14343 захирамжаар иргэний хэрэг үүсгэсэн шүүхээс иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гарсан. 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийж, хамтран ажиллах гэрээ”-г дүгнэж, дуусгавар болгох акт үйлдэн, Шүүхийн шийдвэрийн дагуу “Төрийн орон сууц” ТӨХХК-ийн хариуцан төлөх 24,604,103,971 төгрөгийг “Нью яармаг хаусинг прожект” ХХК үл хөдлөх хөрөнгөөр төлж барагдуулсан. Хөгжлийн банк дахь “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн нэр дээрх “Шинэ яармаг” төслийн зээлийн өр төлбөр төлөгдөж дууссан.<br>3.“МИАТ” ТӨХК-ийн BOEING767-300ER агаарын хөлгийг худалдан авах зориулалтаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | үлдэгдлийг 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр мөнгөн хэлбэрээр төлж, хугацаанаас нь 2 сарын өмнө барагдуулсан.<br><br>4.“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн “Тогтоолын хэрэгжилтийг хангуулах тухай” 31 дүгээр тогтоол гарч, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн “Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 32 дугаар тогтоолоор “...“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Монгол Улсын Хөгжлийн банкнаас зээлсэн зээлийн өр болох 117.2 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын дагуу тус компанид хуваарилж...“ гэж шийдвэрлэсэн. Үүний дагуу 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 117.2 тэрбум төгрөгийг “Эрдэнэс Монгол” ХХК-аас Хөгжлийн банкны Төрийн сангийн зохих дансанд шилжүүлсэн байна. | | |
| 70 | 144 | **Тэмдэглэл**<br><br>2022-03-09, № 15<br><br>XXII.1.5. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. Энэ хүрээнд ТӨБЗГ нь 2022 оны “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоолыг баталж, нэр бүхий төрийн өмчит 25 хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааны 34 хүртэлх хувийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br><br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна.<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажлын хэсэг, Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн удирдлага, албан тушаалтнууд, авто замын засвар, арчлалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит 20 компанийн гүйцэтгэх захирлуудыг оролцуулсан авто замын засвар арчлалтын 20 компанийн цаашдын төлөв байдлын талаар болон “Төрийн өмчит компанийн шинэчлэл болон нэмэлт хувьцаа “IPO” гаргах асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг, цахим уулзалтыг 2023 оны 01 дүгээр 23-ны өдөр зохион байгуулж, уулзалтын тэмдэглэлийг албажуулан Зам, тээврийн хөгжлийн сайдад хүргүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Мөн тус ажлын хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажлын хэсэг автозам засвар арчлалтын компаниудын болон “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн нэмэлт хувьцаа “IPO” гаргах талаар танилцуулга болон тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх санал зэргийг танилцуулсан. Үүний үр дүнд Засгийн газрын 244 дүгээр тогтоолд зохих өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br><br>“Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO гаргахаар бэлтгэж байна. Төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй компани болгох ажлын хүрээнд авто замын засвар, арчлалтын чиглэлээр ажилладаг төрийн өмчит 20 компанийг нэгтгэн “Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, түүний энгийн хувьцааг нэмж гаргах, биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн 05 дугаар тэмдэглэл гаргасан бөгөөд холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр тогтсон.<br><br>“Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК болгон өөрчлөн зохион байгуулж, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд нээлттэй худалдах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-1/448 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 220 дугаар тогтоол гаргасан байна. | | |
| 71 | 145 | **Тэмдэглэл**<br><br>2022-04-08, № 21<br><br>I.1.6. “Суудлын автомашин ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоол, Төрийн албан хаагчийн албан унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>ТӨБЗГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний үнэ тариф, зардлын норм, норматив болон Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишгийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн ажлын хүрээнд дараах ажлуудыг хийв:<br><br>2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203, 204 дүгээр тогтоолоор энэхүү тэмдэглэлд заасан холбогдох арга хэмжээг авсан. Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх | “Хэрэгжих шатанд” - 70% | Цаашид хяналтаас хасах саналтай.<br><br>Уг заалтад заасан агуулгаар Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоол гарсан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолоор төрийн албанд ашиглагдах суудлын автомашины хэрэглээг зохицуулж, суудлын автомашин ашиглах эрх бүхий 21 албан тушаалтны жагсаалтыг баталж, холбогдох бусад арга хэмжээг авсан байна. Уг тогтоолоор “Суудлын автомашин ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон.<br><br>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталсан. Журмыг мөрдөх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Чиглэл хүргүүлж, санал авах тухай” А-1/194 дүгээр албан бичгээр төрийн өмчит хуулийн этгээдүүдэд чиглэл хүргүүлэв.<br><br>Засгийн газрын 2022 оны 203 тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2002 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга хэрэгслийн нийтлэг жишиг”-ийг шинэчлэн батлуулах зорилгоор холбогдох судалгааг хийж байгаа бөгөөд энэ асуудлаар Сангийн яамны холбогдох газар, хэлтэстэй хамтран ажиллаж байна. Бүгд Найрамдах Турк улс, Болгар, Казахстан, Хятад ард улсуудын төрийн захиргааны байгууллагын албан ажлын өрөө, тасалгааны нийтлэг жишиг, стандартын журмыг орчуулан судалж байна. | | Эдгээр тогтоолыг хяналтад авч хэрэгжүүлж байгаа холбогдох заалтаар тайлагнаж байгаа болно. |
| | 146 | **Тэмдэглэл**<br><br>2022-04-08, № 21<br><br>I.1.7. Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Улсын Их Хурлын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолууд гарсан. Уг тогтоол шийдвэрээр “Төрийн банк” ТӨХХК-ийн 20 хүртэлх хувийг үе шаттайгаар олон нийтэд арилжаалах, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 34 хүртэлх хувийг 2022 оны IV улиралд багтаан, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Үндэсний давхар даатгал” ТӨХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ, авто замын засвар, арчлалтын | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит 20 хувьцаат компани зэрэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 34 хүртэлх хувийг 2023 оны IV улиралд багтаан тус тус нээлттэй худалдахаар шийдвэрлэсэн.<br><br>Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай анхдагч хуулийн төсөлд тусгаж байгаа болно.<br><br>УИХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5-д “...Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно...”, 6-д “...Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.5-д заасан улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээд биржээр арилжаалах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг эзэмшихийг хориглоно...”, 7-д “...Энэ хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална...” гэж тус тус заасан өөрчлөлтийг оруулсан.<br><br>“Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO гаргаж, хөрөнгийн биржээр олон нийтэд арилжих ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд амжилттай хэрэгжиж байна. | | |
| 72 | 147 | **Тэмдэглэл**<br><br>2022-05-11, № 28<br><br>XYI.12. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх улсын тусгай хэрэгцээний газраас 50 га талбайг ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүс байгуулах зориулалтаар тусгай хэрэгцээнд авч, “Монголросцветмет” ТӨҮГ-т олгох асуудлыг холбогдох журмын дагуу судалж, танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт, **гаалийн хяналтын бүс** | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Монголросцветмет” ТӨҮГ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүс байгуулах асуудлыг судлан холбогдох судалгаа, тооцоо хийж, гарах үр дүн, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан.<br><br>Тэмдэглэлд тусгагдсан газрын зөвшөөрлийн асуудал шийдвэрлэгдээгүй байна. Засгийн газрын хуралдаанд “Монголросцветмет” ТӨҮГ-т ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүс байгуулах зориулалтаар 50 га газар олгуулах асуудлыг танилцуулах ажил хүлээгдэж байна.<br><br>Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг дарга Б.Анхбаяр, ИТХ-ын дарга Н.Алдарбаяр нартай “Монголросцветмет” ТӨҮГ-ын удирдлагууд уулзаж, тулгамдсан асуудлыг танилцуулсан. Орон нутгийн | “Хэрэгжих шатанд”-70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **байгуулснаар гарах үр дүн, техник, эдийн засгийн үндэслэлийг танилцуулахыг** Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), **“Монголросцветмет” ТӨҮГ-ын захирал (Б.Мөнхбат) нарт;** | удирдлагуудын зүгээс 2022 оны 11 дүгээр сард болох сумын ИТХ-аар “Монголросцветмет” ТӨҮГ-т ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүс байгуулах зориулалтаар 50 га газрыг олгох асуудлыг хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байгаа тухай мэдэгдсэн байна. | | |
| | 148 | **Тэмдэглэл**<br>2022-05-11, № 28<br>XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, **тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.** | **ТӨБЗГ – МТА**<br>Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бүх албан хаагчдад тоон гарын үсэг авах ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>Албан хаагчдыг тоон гарын үсэг хэрэглэх боломжийг судалж, тоон гарын үсгийг хэрхэн авах, түүний ач холбогдол, хэрэглэх талаар албан хаагчдыг мэдээлэл, заавар, арга зүйгээр хангах ажлыг хийв.<br>Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран, 2022 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 1-ний өдрүүдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдад тоон гарын үсэг авах ажлыг ажлын байранд зохион байгуулсны дүнд нийт 32 албан хаагч тоон гарын үсэг авсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| 73 | 149 | **Тэмдэглэл**<br>2022-05-18, № 29<br>XIY.3.3. Циркийн урлагийн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах чиг үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсэг байгуулж ажиллан саналаа 2022 оны 10 дугаар сард багтаан танилцуулахыг Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төрийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ**<br>Соёлын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/267, А/1035, А/48 дугаартай хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2 дахь удаагийн хурал 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан. Ажлын хэсгийн өмнөх хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу Үндэсний архивын газар хадгалагдаж буй Циркийн хувьчлалтай холбоотой 40 гаруй бодит материалыг нэг бүрчлэн үзэж, холбогдох материалыг хувилж авч танилцан судалсан бөгөөд эдгээр материалуудад тулгуурлан ТӨБЗГ-ын төлөөллийн зүгээс Циркийн хувьчлал болон “Худалдах, худалдан авах тухай” 399 дүгээр гэрээний биелэлтийн | “Хэрэгжих шатанд”- 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгав; | талаар холбогдох мэдээллийг ажлын хэсэгт танилцуулсан. Мөн “АСА консалтинг” ХХК-ийн төлөөлөл циркийн барилгын хөрөнгө оруулалтын талаар танилцуулга хийсэн. Ажлын хэсэг “АСА консалтинг” ХХК-ийн гүйцэтгэх удирдлагыг байлцуулан 14 хоногийн дараа дахин хуралдахаар шийдвэрлэсэн бөгөөд Ажлын хэсгийн хурлаас тус компанийн төлөөлөлд холбогдох хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн болно. Хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийн талаар “АСА консалтинг” ХХК-иас хариу ирүүлээгүй ба ажлын хэсэг дахин хуралдаагүй байна.<br><br>Соёлын яамнаас Монголын Үндэсний циркт 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 6/400 дугаартай "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгийг хүргүүлсний дагуу АСА циркээс 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 23/03 дугаартай албан бичгээр хариу мэдэгдсэн. Уг хариу албан бичгээр “Барилгын зураг төсөл батлагдаж гараагүй байна, батлагдахаар нь шаардлагатай материалуудыг танилцуулах болно. Мөн М.Отгонцэцэг захирал гадаадаас ирсэн ажлын хэсгийн ахлагчтай боломжтой цаг товлон уулзана” гэдгээ мэдэгдсэн байна. | | |
| | 150 | **Тэмдэглэл**<br><br>2022-05-18, № 29<br><br>XIY.3.4. Төрийн өмчийн хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, “Аса консалтинг” ХХК хооронд улсын циркийн урлагийн мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр, зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгөөр байгуулсан “Худалдах, худалдан авах гэрээ №399” болон үүнтэй холбогдож гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.”. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ**<br><br>Соёлын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2 дахь удаагийн хурал 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан. Ажлын хэсгийн өмнөх хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу Үндэсний архивын газар хадгалагдаж буй Циркийн хувьчлалтай холбоотой 40 гаруй бодит материалыг нэг бүрчлэн үзэж, холбогдох материалыг хувилж авч танилцан судалсан бөгөөд эдгээр материалуудад тулгуурлан ТӨБЗГ-ын төлөөллийн зүгээс Циркийн хувьчлал болон “Худалдах, худалдан авах тухай” 399 дүгээр гэрээний биелэлтийн талаар холбогдох мэдээллийг ажлын хэсэгт танилцуулсан.<br><br>Төрийн өмчийн хорооны 2006 оны 630 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын циркийг удирдах үйл ажиллагааг гүйцэтгэж, менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах баг сонгон шалгаруулах нээлттэй уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам”-ын 1.4-д “...Уралдаант шалгаруулалтад шалгарсан этгээд нь “Менежментийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ биелүүлж, өмчлөгч болсон нөхцөлд Стратегийн төлөвлөгөөгөө 2007-2011 он хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах тухай гэрээг БСШУЯ-тай байгуулна...” гэж заасан боловч энэхүү гэрээнүүд хийгдээгүй байна. ТӨХ-ны 2008 оны 352 дугаар тогтоолын 5-р заалтаар Улсын циркийн | “Хэрэгжиж байгаа шатанд”- 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | балансад бүртгэлтэй хуучин циркийн барилгыг төрийн мэдэлд үлдээж, циркийн сургуулийн зориулалтаар Хөгжим бүжгийн коллежийн мэдэлд түр эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн тул “Соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах тухай гэрээ”-г БСШУЯ-тай байгуулах шаардлагагүй болсон гэж үзэж байна. Харин “Менежментийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ биелүүлж, өмчлөгч болсон нөхцөлд “Стратегийн төлөвлөгөөгөө үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэрээ”-г БСШУЯ-тай байгуулаагүй байна. | | |
| 74 | 151 | **Тэмдэглэл**<br>2022-05-25, № 30<br>I.4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн байршуулах талаар санал боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК (О.Хулан) нарт даалгав. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн байршуулах талаар холбогдох санал авч, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан байна. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа аж ахуйн нэгжүүдийг оффисыг 2024 оны 1 дүгээр улирлаас шилжүүлэн байршуулахаар уг төлөвлөгөөнд тусган ажиллаж байгаа талаар тус компаниас санал ирүүлсэн байна.<br>Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс “Эрдэнэс Тавантолгой” ХХК нь орон нутагт болон Улаанбаатарт оффисгүй тул нийслэлд төв оффис барьж бий болгохоор 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөндөө тусгаж санал оруулсныг хянаж, чиглэл өгснөөр төлөвлөгөөний төслөөс хасуулж шийдвэрлэсэн. Ингэснээр Цогтцэций суманд байршиж үйл ажиллагаагаа явуулахаар болсон.<br>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Өмнөговь аймаг дахь газрын шинэ оффисын барилгыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ашиглуулахаар тогтож Засгийн газрын тогтоолоор Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газарт балансаас балансад шилжүүлсэн. Одоо ашиглалтын гэрээ байгуулах, байршуулах ажлыг зохион байгуулна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 75 | 152 | **Тэмдэглэл**<br>2022-06-22, № 34<br>XII.1.2. “Монгол ган” цогцолбор I төслийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр төслийн ТЭЗҮ, санхүүжилт, эрчим хүч, тээвэр логистик зэрэг дэд бүтцийн тулгамдсан асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Монгол ган цогцолбор I” төслийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр төслийн ТЭЗҮ, санхүүжилт, эрчим хүч, тээвэр логистик зэрэг дэд бүтцийн тулгамдсан асуудлаар “Шинэ сэргэлт-Монгол ган” хэлэлцүүлгийг 2022 оны 7 сарын 4 өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-иас “Монгол ган цогцолбор I” төслийн танилцуулга, тулгамдсан асуудлуудыг танилцуулсан.<br>Хэлэлцүүлэгт оролцсон холбогдох эрх бүхий байгууллага болох Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Эрчим хүчний | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК (А.Ариунболд) нарт; | яам, “Улаанбаатар төмөр зам” ХНН төслийн тулгамдсан асуудлуудтай холбоотой илтгэл тавьж, асуудлуудыг шийдвэрлэх шийдэл, зөвлөмж гаргасан.<br><br>“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг бүс нутгийн уул уурхай, металлургийн кластер хэлбэрээр хөгжүүлэх талаар судлан тус үйлдвэрийг “Эрдэнэс Монгол нэгдэл” ХХК-ийн бүрэлдэхүүнд ажиллуулах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 22 дугаар тэмдэглэл гарсан бөгөөд уг тэмдэглэлийг 2022 оны А-1/2102 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар Засгийн газрын 2022 оны 429 дүгээр тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол нэгдэл” ХХК-ийн бүрэлдэхүүнд ажиллуулахаар шийдвэрлэсэн болно.<br><br>Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн металлургийн цогцолбор байгуулах ажлын хүрээнд "Монгол ган цогцолбор-I" төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 оны 12 дугаар сард УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан. Батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу цогцолбор байгуулах ажлын төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сард боловсруулан компанийн Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Уг төлөвлөгөөгөөр 2023 оны 06 дугаар сард үйлдвэрийн шавыг тавьж, газар шорооны тэгшилгээ, суурийн ажлыг эхлүүлэх ба төслийг нийт 36 сарын хугацаанд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна. Холбогдох төлөвлөгөөнд тодотгол хийгдэнэ. | | |
| 76 | 153 | **Тэмдэглэл**<br><br>2022-06-29, № 35<br><br>XXYII.8. Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд хэрэгжүүлж буй “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” жишиг төслийн бүтээн байгуулалтын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн жишиг болох, Бэрхийн уурхайд суурилсан “Монголын далд | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>2023 оны эхний хагас жилийн байдлаар Эрдсийн музейн барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Уурхайд орох агаарыг уурын зуухны дулаанаар халаах ажил (ажлын зураг төсөл, тоног төхөөрөмжийн угсралт)-ын тендер зарласан. Монголын үйлдвэрлэлийн түүхэн танхимын тохижилт, заслын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн. Монголын уул уурхайн үүсэл хөгжлийн танхимын тохижилт, заслын ажлын, уулзалтын өрөөний ажлын, цахим үзүүлбэрийн өрөөний ажлын тендер зарлаж, нээсэн, үнэлгээний хороо үнэлгээ хийж байна. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил 2021, 2022, 2023 он дамжин хийгдэж байна. Төслийн гадна тохижилтын ажил 60 хувь, “Очирваань” бурхан бүтээх, хүслээ даатгах танхимын тохижилтын ажлын тендер зарласан, VR өрөөний угсралт, заслын ажил 30 хувь, газрын доорх байгууламжуудын инженерийн | “Хэрэгжих шатанд”-70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн бүтээн байгуулалтыг төлөвлөсөн хугацаанд дуусгахад төслийн нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн судалж шийдвэрлэх, жишиг нөхөн сэргээлтийн бүтээн байгуулалтын ажилд уул уурхайн салбарын төрийн өмчит томоохон компаниудын оролцоог хууль тогтоомжид нийцүүлэн хангуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | хангамж /халаалт агаар сэлгэлт, цэвэр бохир ус, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг, холбоо дохиолол/-ийн ажил 100 хувийн тус тус гүйцэтгэлтэй. Газрын доорх байгууламжийн агааржуулалтын системийн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ажил бүрэн хийгдсэн байна. | | |
| 77 | 154 | **Тэмдэглэл**<br>2022-08-17, № 41<br>YIII.4.3. “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн урсгал зардлыг тооцож үзсэний үндсэн дээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эгийн голын усан цахилгаан станцын биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг дуусгаж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлэх” гэж тусгасны дагуу төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2023 оны зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн нэгжээс боловсруулав. Үйл ажиллагааны зардалд нийт 3,010.19 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт тусгуулахаар саналаа ЭХЯ-нд 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/50 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд ЭХЯ-ны 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн а/3133 тоот албан бичгээр уг төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлсэн байна. Улсын төсөв батлагдахад 1,500.0 сая төгрөг тусгагдсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| 78 | 155 | **Тэмдэглэл**<br>2022-08-24, № 42<br>YIII.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн шинэчлэлийн бодлогын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Шинжлэх ухааны академийн Геологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Газарзүй, геоэкологийн хүрээлэн, Одон орон, геофизикийн хүрээлэнг нийлүүлэх асуудлаар Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчит төсөвт байгууллагуудтай холбоотой уг асуудлыг холбогдох яамдаас мэдээлэл авч, судалж байна. Тухайн чиг үүргийн яамны санал Засгийн газарт танилцуулагдана.<br>Төрийн өмчит хуулийн этгээдийн шинэчлэлийн бодлогын хүрээнд геологи, уул уурхайн салбараас эхний ээлжид төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болох “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газар болон “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нэгтгэн “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨААТҮГ болгон өөрчлөн зохион байгуулах асуудлыг Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн өмчит зарим | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Төрийн өмчит төсөвт байгууллагыг өөрчлөн зохион байгуулах асуудал ТӨБЗГ-ын шууд хариуцах асуудал |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | харгалзан холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан 2022 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгав. | үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай" 317 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.<br>Төрийн өмчит төсөвт байгууллагыг өөрчлөн зохион байгуулах асуудлыг ТӨБЗГ хариуцах чиг үүрэггүй болно. Иймээс салбарын яам хариуцах тул ТӨБЗГ-т шууд хамаарахгүй байна. | | биш, тухайн салбарын яам хариуцна.<br>Тиймээс цаашид хяналтаас хасуулах саналтай. |
| | 156 | **Тэмдэглэл**<br>2022-08-24, № 42<br>XY.2.2.1.Хөгжлийн банкнаас зээл авсан төрийн байгууллагын удирдлага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Засгийн газрын холбогдох гишүүд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран дүгнэлт гаргах, "Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, холбогдох арга хэмжээг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авч, хариуцлага тооцож ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Хөгжлийн банкны өр, зээлтэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК, "Цемент шохой" ТӨХК, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, "Монгол Улсын Хөгжлийн банк"-ХХК-ийн Гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллуулсан. Засгийн газрын 2022 оны "Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай" 220 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдсан.<br>"Монгол Улсын Хөгжлийн банк" ХХК-аас "Хөтөл" ХХК-ийн авсан өр төлбөртэй холбоотой Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дээр Зээлийн гэрээний үүрэгт 389,055,659,842.00 төгрөгийг гаргуулах талаар хэрэг үүссэн байгаа бөгөөд тус хэрэгт хамтран хариуцагчаар "Цемент шохой" ТӨХК оролцож байна. Тус хэргийн оролцогчидтой холбоотой эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх, арбитрын журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргаан ("Бэйзмэнт" ХХК ("Хөтөл" ХХК)-ийн өв залгамжлагч нь Б.Тулга мөн эсэх асуудал тодорхой болох хүртэл)-ыг хянан шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй үндэслэлээр түдгэлзсэн байна. Шүүх хурал 18 удаа хойшилсон ба одоогийн байдлаар дээрх шалтгааны улмаас түдгэлзсэн байна. | "Хэрэгжих шатанд"-70% | |
| 79 | 157 | **Тэмдэглэл**<br>2022-09-14, № 45<br>XX.2. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны Хоёрдугаар байрны түрээсийн гэрээний хугацаа дуусгавар | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар холбогдох ажлын хэсгийг ТӨБЗГ-ын төлөөллийг оролцуулан байгуулсан бөгөөд ОХУ-ын Москва хот дахь Элчин сайдын яамны эзэмшилд байгаа Хоёрдугаар байрны түрээслэгч "Центр регион эстейт" компанийн зүгээс байрыг хүлээн авах, тус байрын засвар, тохижилтод | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | болж буйтай холбогдуулан тухайн байрыг түрээслэгчээс хүлээн авах ажлын явцыг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны Хоёрдугаар байрны түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болж буйтай холбогдуулан түрээслэгч “Центр регион эстэйт” компанитай үүссэн өр төлбөрийн асуудлаар монголын талд ашигтай хувилбараар хэлэлцээ хийх, өр төлбөргүйгээр эцэслэн шийдвэрлэх, тус байрыг хүлээн авах чиглэлээр ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгав. | зарцуулсан хөрөнгийн хэмжээг үнэлэх болон холбогдох стандарт, арга зүйн дагуу хэмжээг бодитой тогтоож, цаашид уг байртай холбогдуулан авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br><br>“Центр регион эстейт” компаниас нийт 1.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт, засвар сайжруулалтын дүнг нэхэмжилж, тухайн үедээ албан бичиг ирүүлсэн боловч уг дүнг хүлээн зөвшөөрөх боломжгүй байсан бөгөөд манай талаас мөн нэхэмжлэх авлагын асуудлаар тооцоо, судалгаа хийж, өр, авлагагүйгээр эцэслэн шийдвэрлэх саналыг хүргүүлсэн. Тус компаниас дахин Элчин сайдын яаманд хандаагүй байгаа бөгөөд ашиглалтын зардлын тооцоо нийлэх, төлбөр барагдуулах ажил хийгдсэн байна.<br><br>Элчин сайдын яам Хоёрдугаар байрыг “Центр регион эстейт” компаниас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр албан ёсоор актаар хүлээн авч, байрыг чөлөөлсөн.<br><br>Тус байрыг төрийн өмчид хүлээн авч, үр ашигтай ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээг авах зорилгоор Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны Хоёрдугаар байрыг Худалдааны төлөөлөгчийн газар, Соёлын төвийн зориулалтаар ашиглахад дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын хуулийн этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. | | |
| | 158 | **Тэмдэглэл**<br><br>2022-09-14, № 45<br><br>XX.4.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг байгуулагдаж, уг асуудалтай холбоотой судалгаа хийх, шийдэл гаргах арга хэмжээг судлан боловсруулах арга хэмжээ аван ажиллав. Үүний үр дүнд “Монгол шуудан” ХК-ийн зарим хэсгийг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын хэсэгт шилжүүлэн байршуулах зохион байгуулалтын арга хэмжээг авсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд шинээр байгуулагдсан агентлагийг мөн “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын хэсэгт шилжүүлэхээр шийдвэрлэж, тодорхой засвар үйлчилгээний ажлыг хийсэн. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т холбогдох судалгаа, тооцоолол, зураг төслийн ажлыг гүйцэтгэсэн. | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 159 | **Тэмдэглэл**<br>2022-09-14, № 45<br>XX.4.4. “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг зориулалт бусаар ашиглуулахгүй байхад анхаарч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан)-т тус тус үүрэг болгов. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Судалгаа тооцоолол хийж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тэмдэглэлийн энэ заалтаар өгсөн үүргийг холбогдох байгууллагуудад танилцуулж, анхааралдаа авсан. | “Хэрэгжих шатанд”-70% | |
| 80 | 160 | **Тэмдэглэл**<br>2022-10-10, № 49<br>XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав. | **ТӨБЗГ – МТА**<br>“Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах мэдээллийн систем байхгүй болно. | Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй – ХБ. | Цаашид хяналтаас хасуулах саналтай. |
| 81 | 161 | **Тэмдэглэл**<br>2022-11-09, № 54<br>X.8.10. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын бүтээгдэхүүнийг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглан төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулж, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын бүтээгдэхүүнийг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглан төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулж, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран "Улаанбаатар төмөр зам" ХХН болон компаниудын гүйцэтгэх удирдлагуудад тодорхой чиглэл өгч ажилласан.<br>Засгийн газрын тэмдэглэлийн хүрээнд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-аас “Монголросцветмент” ТӨҮГ нь 100 ш вагоныг авч экспортод ашиглаж байна.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2022 оны 04 дүгээр улиралд нийт 334.2 сая ам. долларын борлуулалтын орлогыг төвлөрүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолд заасан үүргийг 111.4 хувь биелүүлж ажилласан. Мөн экспортын бүтээгдэхүүнийг тээвэрлэх талаар “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй байгуулсан гэрээний дагуу зэс, молибдений баяжмалын | “Хэрэгжих шатанд”-70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тээвэрлэлтийг зохион байгуулж, 2022 оны 11, 12 дугаар сар, 2023 оны 01 дүгээр сарын зэсийн баяжмалын ачилтын төлөвлөгөөг 101.4-103.8 хувь, мөн хугацааны молибдений баяжмалын ачилтын төлөвлөгөөг 128.4-144.2 хувь тус тус давуулан биелүүлсэн байна. | | |
| 82 | 162 | **Тэмдэглэл**<br>2022-11-23, № 56<br>XIX.1.4. “Монголросцветмет” ТӨҮГ-ын экспортын бүтээгдэхүүнийг тээвэрлэх төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Улаанбаатар төмөр зам” ХНН (Х.Хэрлэн), “Монголросцветмет” ТӨҮГ (Б.Мөнхбат)-т; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Монголросцветмет” ТӨҮГ-ын экспортын бүтээгдэхүүнийг тээвэрлэх төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн яам, “Улаанбаатар төмөр зам” ХНН-т хүсэлт хүргүүлсэн бөгөөд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-аас 100 вагоныг тус компанид түрээсээр ашиглуулж байна. | “Бүрэн хэрэгжсэн”-100% | Бүрэн хэрэгжиж, зохион байгуулал-тын арга хэмжээ авагдсан тул хяналтаас хасах саналтай. |
| | 163 | **Тэмдэглэл**<br>2022-11-23, № 56<br>XIX.1.5. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор “Төмөртэй” өртөөний үйл ажиллагааг сэргээх арга хэмжээ авахыг “Монголын төмөр зам” ТӨХК (П.Ганхүү), “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК (Г.Дугаржав)-д; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Монголын төмөр зам” ТӨХК-тай төмөр замын тээврийн гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж, энэ үеэр төмөр замын гэрээний төлбөрийн асуудлын талаар тусгайлан хэлэлцсэн. | “Бүрэн хэрэгжсэн”-100% | Бүрэн хэрэгжиж, зохион байгуулал-тын арга хэмжээ авагдсан тул хяналтаас хасах саналтай. |
| 83 | 164 | **Тэмдэглэл**<br>2022-12-07, № 58<br>XXI.1.2. Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх чиглэлээр Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд зөвлөмж, чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан.<br>Засгийн газрын 2022 оны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолын 3 | “Бүрэн хэрэгжсэн”-100% | Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдааны 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, тэдгээрийг томилох эрх бүхий этгээдэд; | дахь заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар улсын гадаад валютын нөөц нэмэгдэж байна.<br><br>Тухайлбал, уул уурхай, ашигт малтмалын үйлдвэрлэл эрхэлдэг дараах томоохон компани, үйлдвэрийн газрууд тогтоолын хэрэгжилтийг хангаж, төлөвлөгөөг давуулан биелүүлсэн үр дүнтэй байна:<br><br>1. “Эрдэнэс Тавантолгой" ХК 2022 он дуустал 500 сая ам.долларын орлого төвлөрүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн. Засгийн газрын тогтоолоор тус компанид онцгой дэглэм тогтоосноос хойш нүүрс экспортыг 2 дахин, нүүрс тээврийг 4 дахин нэмэгдүүлэн 11.2 сая тонн нүүрс олборлож, төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн. Борлуулалтын орлогыг 1.1 тэрбум ам.долларт хүргэсэн байна.<br>2. “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь 2022 оны 04 дүгээр улиралд нийт 334.2 сая ам.долларын борлуулалтын орлогыг төвлөрүүлж, 111.4%-ийн гүйцэтгэлтэй буюу тогтоолоор хүлээсэн үүргээ давуулан биелүүлсэн. Түүнчлэн, дээрх хугацаанд Монгол банканд нийт 300.0 сая ам.доллар арилжсан.<br>3. "Монголросцветмет" ТӨҮГ нь 2022 оны 4-р улиралд 18.0 сая ам.доллар төвлөрүүлсэн бол 2023 онд 6 дугаар сарын байдлаар Монголбанканд 21.96 сая ам.долларыг худалдаад байна.<br>4. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь 15.0 сая ам.доллар төвлөрүүлэхээс 2022 оны 4 дүгээр улиралд 7.2 сая ам.долларын орлого төвлөрүүлсэн байна. 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 15.1 сая ам. долларын орлого төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөг 100.5 хувиар биелүүлсэн мэдээтэй байна. | | цаашид хэрэгжилтийг хянах боломжтой, ижил агуулгатай дараагийн тогтоол шийдвэр гарсан, зарим үүрэг даалгавар нь бүрэн хэрэгжиж, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. Цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 165 | **Тэмдэглэл**<br><br>2022-12-07, № 58<br><br>XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх | **ТӨБЗГ – МТА**<br><br>Зохион байгуулалтын арга хэмжээ авах талаар анхааран судалж байна. Тухайн системийг судалж, холбогдох байгууллагатай хэрхэн холбоос үүсгэж, ашиглах талаар мэдээлэл, арга зүйн чиглэл, зөвлөмж авах шаардлагатай.<br><br>Төрийн байгууллага хоорондын албан бичгийн солилцоог цахим хэлбэрээр хийх шийдлийг хэрэгжүүлэх чиглэлээр 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан цахим сургалтад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдыг хамруулж, https://docx.gov.mn цахим системийн талаарх ойлголт, мэдээллийг өгсөн бөгөөд системийн хэрэглээ, ашиглалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд анхаарч байна. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30%. | Зохион байгуулал-таас шалтгаалж удааширч байгаа. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | | | |
| 84 | 166 | **Тэмдэглэл**<br>2022-12-12, № 61<br>XIX.1. “Соёлын төв өргөө”-ний ашиглалтын нөхцөл байдлын талаар Соёлын сайд Ч.Номин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Соёлын төв өргөө”-ний байрны өмчлөлийн асуудлыг судалж эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр саналаа танилцуулахыг Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Соёлын төв өргөөг УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчид шилжүүлсэн тул ТӨБЗГ-аас уг асуудлаар шийдвэр гарахгүй байхаар эрх зүйн зохицуулалттай талаар Соёлын дэд сайд М.Батбаярт 2022 оны А-1/2227 дугаар албан бичгээр тайлбар хүргүүлсэн.<br>Соёлын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Соёлын төв өргөө"-ний байрны өмчлөлийн асуудлыг судалж, эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр санал танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ТӨБЗГ-аас ажиллах албан хаагчийн нэрийг 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А-1/959 дугаартай албан бичгээр Соёлын яаманд хүргүүлсэн. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30%. | Зохион байгуулал-таас шалтгаалж удааширч байгаа. |
| 85 | 167 | **Тэмдэглэл**<br>2023-01-18, № 4<br>VIII.2. 2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашины талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгав: 2.1.төрийн өмчийн ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн автомашинуудыг данснаас хасаж, засвар үйлчилгээ хийж сэргээх, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож орон нутгийн өмчид бүртгэх асуудлыг тухай бүр нь зохих журмын дагуу шийдвэрлэж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; 2.2.төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн суудлын автомашины ашиглалтыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хамтарсан 95/280 дугаар тушаалаар | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>1. Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг өргөн мэдүүлж, УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай асуудлыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцсэн байна.<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн болон Мэргэжлийн хяналтын газар (татан буугдсан)-ын эзэмшилд байсан автомашин болох нийт 114 автомашиныг дараах байдлаар шийдвэрлүүлж байна:<br>a. Үлдэх өртөгтэй 54 автомашиныг УИХ-ын тогтоолд тусгаж, шийдвэр гарах хүртэл орон нутгийн өмчит эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад ашиглалтын гэрээ байгуулан хүлээлцэж, алслагдсан сумын төрийн үйл ажиллагаанд ашиглуулах ажлыг зохион байгуулсан. Эвдрэл гэмтэлтэй зарим автомашиныг хүлээлцээгүй, засвар хийх, эсвэл өөр автомашинаар сольж шийдвэрлүүлэхээр хүлээж байна.<br>b. Үлдэх өртөггүй 60 автомашиныг данснаас хасаж, засвар үйлчилгээ хийж сэргээх, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, орон нутгийн өмчид бүртгэх асуудлыг Төрийн өмчийн | “Хэрэгжих шатанд”- 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | баталсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын дагуу зохицуулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 26 дугаар тогтоолоор шийдвэрлэсний дагуу орон нутгийн холбогдох байгууллагад хүлээлцүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>c. Мөн татан төвлөрүүлсэн автомашинаас зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байгууллагад балансаас баланст шилжүүлэх, худалдаж орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж байна.<br><br>2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах журам”-ыг мөрдөх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Чиглэл хүргүүлж, санал авах тухай” А-1/194 дүгээр албан бичгийг төрийн өмчит бүх шатны байгууллагад хүргүүлсэн. | | |
| | 168 | **Тэмдэглэл**<br><br>2023-01-18, № 4<br><br>X.2. “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Төмөр замын экспортын тээвэрлэлтийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт тус тус Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br><br>1.Төрийн өмчид бүртгэлтэй ачааны хагас вагоныг тэргүүн ээлжид төрийн өмчит хуулийн этгээдэд ашиглуулж байх, гадаад валютын нөөцийг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой хуваарилалт хийх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын бүтээгдэхүүнийг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглан төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулж, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран "Улаанбаатар төмөр зам" ХХН болон компаниудын гүйцэтгэх удирдлагуудад тодорхой чиглэл өгч ажилласан.<br><br>“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-аас “Монголросцветмент” ТӨҮГ нь 100 ш вагоныг түрээсээр авч, экспортод ашиглаж байна.<br><br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь экспортын бүтээгдэхүүнийг тээвэрлэх талаар “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй байгуулсан гэрээний дагуу зэс, молибдений баяжмалын тээвэрлэлтийг зохион байгуулж байна.<br><br>Засгийн газрын 2022 оны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар улсын гадаад валютын нөөц нэмэгдэж байна. Тухайлбал, уул уурхай, ашигт малтмалын үйлдвэрлэл эрхэлдэг дараах томоохон компани, | “Бүрэн хэрэгжсэн”-100% | Бүрэн хэрэгжиж, зохион байгуулал-тын арга хэмжээ авч хэрэгжүүл-сэн, хэрэгжилт тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | үйлдвэрийн газрууд тогтоолын хэрэгжилтийг хангаж, төлөвлөгөөг давуулан биелүүлсэн үр дүнтэй байна:<br>1. “Эрдэнэс Тавантолгой" ХК 2022 он дуустал 500 сая ам.долларын орлого төвлөрүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн. Засгийн газрын тогтоолоор тус компанид онцгой дэглэм тогтоосноос хойш нүүрс экспортыг 2 дахин, нүүрс тээврийг 4 дахин нэмэгдүүлэн 11.2 сая тонн нүүрс олборлож, төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн. Борлуулалтын орлогыг 1.1 тэрбум ам.долларт хүргэсэн байна.<br>2. “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь 2022 оны 04 дүгээр улиралд нийт 334.2 сая ам.долларын борлуулалтын орлогыг төвлөрүүлж, 111.4%-ийн гүйцэтгэлтэй буюу тогтоолоор хүлээсэн үүргээ давуулан биелүүлсэн. Түүнчлэн, дээрх хугацаанд Монгол банканд нийт 300.0 сая ам.доллар арилжсан.<br>3. "Монголросцветмет" ТӨҮГ нь 2022 оны 4-р улиралд 18.0 сая ам.доллар төвлөрүүлсэн бол 2023 онд 6 дугаар сарын байдлаар Монголбанканд 21.96 сая ам.долларыг худалдаад байна.<br>4. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь 15.0 сая ам.доллар төвлөрүүлэхээс 2022 оны 4 дүгээр улиралд 7.2 сая ам.долларын орлого төвлөрүүлсэн байна. 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 15.1 сая ам. долларын орлого төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөг 100.5 хувиар биелүүлсэн мэдээтэй байна. | | |
| | 169 | **Тэмдэглэл**<br>2023-01-18, № 4<br>Х.2.2. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн түрээслүүлж байгаа ачааны хагас вагоны түрээсийн гэрээ дуусмагц тэдгээр вагоныг “Монголросцветмет” ТӨҮГ-т ашиглуулах арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Дугаржав нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-аас “Монголросцветмет” ТӨҮГ нь 100 ш вагоныг түрээсээр авч, экспортод ашиглаж байна. Түрээсийн гэрээ дуусахаар тухайн асуудлыг шийдвэрлэх талаар санал солилцсон. | “Хэрэгжих шатанд”- 70% | |
| 86 | 170 | **Тэмдэглэл**<br>2023-01-25, № 5<br>Х.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**<br>“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг байгууллага, нэгжийн 2023 оны | “Бүрэн хэрэгжсэн”- 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. | гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, дунд, богино хугацааны улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахад “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн холбогдох зорилт, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж холбогдох байгууллагад санал хүргүүлэн ажиллаж байгаа болно. Тухайлбал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр боловсруулахдаа уялдаа холбоог хангаж, уг үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх чиглэлийг баримталсан. | | |
| | 171 | **Тэмдэглэл**<br>2023-01-25, № 5<br>X.1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшнийг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**<br>“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг байгууллага, нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, дунд, богино хугацааны улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахад “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн холбогдох зорилт, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж холбогдох байгууллагад санал хүргүүлэн ажиллаж байгаа болно. Тухайлбал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр боловсруулахдаа уялдаа холбоог хангаж, уг үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх чиглэлийг баримталсан. | “Бүрэн хэрэгжсэн”-100% | |
| | 172 | **Тэмдэглэл**<br>2023-01-25, № 5<br>X.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан хэрэгжүүлэхээр уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газрын болон өөрийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, дүгнэлт, зөвлөмжийг албан хаагчид, удирдлагад танилцуулж, мэдээлэл, арга зүйгээр ханган хэрэгжүүлэх арга хэмжээг авсан болно. Холбогдох арга хэмжээг байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. | “Бүрэн хэрэгжсэн”-100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов. | Хэрэгжилтийн явцыг сар бүр хянаж, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цахим системээр дамжуулан мэдээлж байна. | | |
| 87 | 173 | **Тэмдэглэл**<br>2023-02-01, № 6<br>XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ, ХЭЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, МТА**<br>Тайлант хугацаанд ямар нэгэн судалгааг захиалгаар хийлгээгүй, зөвлөх үйлчилгээний захиалга аваагүй байна.<br>Цаашид уг заалтаар өгсөн үүрэг чиглэлийг тухай бүрд хэрэгжүүлэх талаар анхаарч байна. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 88 | 174 | **Тэмдэглэл**<br>2023-02-20, № 9<br>IY.2.2. “Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024” арга хэмжээнд оролцох нэгдсэн зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК (Б.Мөнхбат) нарт даалгав. | **ТӨУЗГ – ТӨУЗХ**<br>Холбогдох байгууллагуудтай хамтран уг олон улсын арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангуулахад анхааран ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 89 | 175 | **Тэмдэглэл**<br>2023-03-01, № 10<br>XY.1. Иргэдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зорилгоор эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх орны хүртээмж, шаардлагатай эмнэлгийн байр, эрүүл мэндийн төвийн хүчин чадлын талаарх судалгааг гарган танилцуулахыг Эрүүл мэндийн сайд | **ТӨУЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ**<br>Авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас төрд хураагдсан болон төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд дэх эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний төв, сургуулийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр ашиглах боломжтой байрны талаарх мэдээллийг гаргах, холбогдох судалгаа хийх ажил хийгдэж байна. | “Хэрэгжээ-гүй” – 0% | Зохион байгуулал-таас шалтгаалж удааширч байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | С.Чинзоригт, **авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас төрд хураагдсан болон төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд дэх эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний төв, сургуулийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр ашиглах боломжтой байрны талаарх мэдээллийг гарган танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)** нарт даалгав. | | | |
| 90 | 176 | **Тэмдэглэл**<br>2023-03-29, № 14<br>XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: 3.Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг тогсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас одоогоор гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдан суралцаж байгаа төрийн албан хаагч байхгүй байна. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 91 | 177 | **Тэмдэглэл**<br>2023-04-12, № 16<br>XIX.1.4. ... Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, үйлдвэрийн захирлын асуудлаарх ажилчдын шаардлагыг нягтлан шалгаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн ажилтнуудын төлөөлөл, Үйлдвэрчний эвлэлийн хорооноос 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр гаргасан гомдол, хүсэлтэд дурдсан асуудлыг судалж тогтоох үүрэг бүхий Ажлын хэсгийг томилсон. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 14-ний өдрийн хооронд “Цемент шохой” ТӨХК-д ажиллаж, дор дурдсан чиглэлээр үйл | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Зохион байгуулал-тын арга хэмжээ авч, хэрэгжүүл-сэн тул цаашид хяналтаас |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав. | ажиллагаа, баримт материалтай танилцан дүгнэж, тайланг нэгтгэн удирдлагын бүрэлдэхүүнд танилцуулав. Үүнд:<br>1.“Цемент шохой” ТӨХК-ийн үйлдвэрлэлийн бэлэн байдалтай танилцаж, чулуунцрын аюулгүйн нөөц бүрдүүлэлт зохих хэмжээнд байгаа эсэхийг шалгах;<br>2.“Цемент шохой” ТӨХК-ийн 2022 оны 04 дүгээр сараас хойших хүний нөөцийн чиглэлээр гаргасан Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэртэй танилцаж, хууль зүйн үндэслэлийг хянах;<br>3.Компанийн цалин хөлсний дүрэм журамтай танилцаж, дүгнэлт гаргах. | | хасах саналтай. |
| | 178 | **Тэмдэглэл**<br>2023-04-12, № 16<br>XX.1.2. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Улаанбаатар хотын тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулах, явган хүний болон унадаг дугуйн зам барьж байгуулах зорилтын хүрээнд “Сэлбэ сэргэлт” төслийг хэрэгжүүлэх нэгжийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтцэд байгуулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;** | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 173 дугаар тогтоолоор “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг өөрчлөн баталж, нийт 198 хүртэл орон тоотой байхаар тогтоосон байна. Уг өөрчлөлтөөр “Сэлбэ сэргэлт” төслийн нэгжийг 11 орон тоотой байхаар шинээр бий болгосон. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Зохион байгуулал-тын арга хэмжээ авч, хэрэгжүүл-сэн, хэрэгжилт бүрэн хангагдсан тул цаашид хяналтаас хасуулах саналтай. |
| 92 | 179 | **Тэмдэглэл** | **ТӨБЗГ – ТӨУЗХ** | “Хэрэгжээ-гүй”- 0% | Холбогдох арга хэмжээ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2023-05-03, № 19<br>XYIII.2.4. Улс хоорондын байнгын ачаа тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зорчих зөвшөөрөл олгох эрхийг нүүрс олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлж байгаа “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захиралд хариуцлага тооцох арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав; | Мэдээлэл байхгүй. | | аваагүй, удааширч байна. |
| | 180 | **Тэмдэглэл**<br>2023-05-03, № 19<br>XYIII.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Уг тэмдэглэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бүртгэгдээгүй, заалтын агуулга бүрэн тодорхой бус байгаа тул тайлагнах боломжгүй байна. | “Хэрэгжил-тийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Энэ тэмдэглэл ТӨБЗГ-т бүртгэг-дээгүй байна. |
| | | **Тэмдэглэл: 30 шийдвэрийн 47 заалт** | **100% - 20 заалт; 70% - 19 заалт; 30% - 2 заалт; 0% - 2 заалт;<br>ХБ – 4 заалт.** | **Дундаж үнэлгээ: 78.8%** | |
| **Найм. Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 93 | 181 | **“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>**2023-04-17, № 01**<br>1.3. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ны гүйцэтгэх захирал С.Наранцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэгтгэн хүргүүлэх тухай чиглэл өгсөн албан бичгийг Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудад тус тус хүргүүлэв.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А-1/884 дүгээр албан бичгийг хүргүүлсэн байгууллагууд: Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, “Эрдэнэс Монгол” ХХК зэрэг болно.<br><br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг компани, үйлдвэрийн газрын захирлуудын мэдээлэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цахим хаяг, 1 сарын цалингийн мэдээллийг гаргаж, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А-1/1017 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br><br>“Шил ажиллагаа”-ны хүрээнд https://shilen.gov.mn цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулалтаар ханган ажилласны үр дүнд ТӨБЗГ-ын хариуцан нээлттэй болгох Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой 1551 мэдээлэл уг цахим системд бүртгэгдээд байна. Мөн ТӨБЗГ-тай байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан түрээслэгчдийн судалгаар гарган https://shilen.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан. Уг мэдээлэлд 2017-2023 оны 2944 түрээслэгч, түрээслэгчдийн мэдээлэл хамрагдан нээлттэй мэдээлэгдээд байна. | | |
| | 182 | **“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br><br>**2023-04-17, № 01**<br><br>1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ, ХЭЗХ, ЗУХ, МТА**<br><br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг компани, үйлдвэрийн газрын захирлуудын мэдээлэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цахим хаяг, 1 сарын цалингийн мэдээллийг гаргаж, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А-1/1017 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br><br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл хариуцагчийн ил тод болгож, нээлттэй мэдээлэх мэдээллүүдийг холбогдох хэлтэс, албан тушаалтанд хариуцуулан ил тод болгох ажлыг зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2022 оны хэрэгжилтийн байдлын тайланг гаргаж, удирдлагад танилцуулан Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан https://new.unelgee.gov.mn/transparent/ системийн холбогдох хэсэгт оруулан баталгаажуулж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээнд | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хамруулах арга хэмжээ авсан. Байгууллагын мэдээллийн нээлттэй байдлын тайлангийн дүнг албан хаагчдад танилцуулах, зарим мэдээллийг нээлттэй мэдээлэх шаардлагатай талаар холбогдох албан хаагчдад зөвлөгөө өгөх, нээлттэй байдлыг боловсронгуй болгох чиглэлээр санал солилцох зэрэг арга хэмжээ авав.<br><br>Байгууллагын мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэн цаг үеийн мэдээллээр тогтмол шинэчлэх, гарын авлага, товхимол, мэдээллийг сурталчилгааны тусгай тавиур хэрэгслийг ашиглан албан хаагчид, олон нийтэд сурталчлан таниулах зэргийг хийж гүйцэтгэв. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг холбогдох цахим систем https://shilendans.gov.mn/organization/8324 болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлж байна. Эхний хагас жилийн байдлаар, шилэн дансны нийт 24 төрлийн 83 мэдээллийг мэдээлэхээс 80 мэдээг мэдээлсэн, 3 мэдээг мэдээлэх хугацаа болоогүй байна. | | |
| | | **Албан даалгавар: 1 шийдвэрийн 2 заалт** | **100% - 2 заалт.** | **Дундаж үнэлгээ: 100.0%** | |

**(Нийт 8 төрлийн 93 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 182 заалтын хэрэгжилтийг тайлагнав. 7 шийдвэрийн 10 заалт нэмэгдсэн, 2023.07.05)**

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)

(2023 оны эхний хагас жилийн байдлаар)

| Д/д | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл | Шийд-вэрийн тоо | Хэрэг-жилтийг тооцсон заалтын тоо | Үүнээс: | | | | | Хэрэгжилтийн явцын дүн (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бүрэн хэрэгжсэн (100 %) | Хэрэгжих шатанд (70 %) | Хэрэгжилт хангалтгүй (30 %) | Хэрэг-жээгүй (0 %) | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ.) | |
| 1 | Монгол Улсын хууль | 3 | **42** | 38 | | | | 4 | **100** |
| 2 | УИХ-ын тогтоол | 11 | **26** | 12 | 6 | | 1 | 7 | **85.3** |
| 3 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 5 | **9** | 1 | 8 | | | | **73.3** |
| 4 | Ерөнхийлөгчийн зарлиг | 3 | **4** | 2 | 1 | | | 1 | **90.0** |
| 5 | Засгийн газрын тогтоол | 38 | **50** | 24 | 19 | 2 | | 5 | **84.2** |
| 6 | Ерөнхий сайдын захирамж | 2 | **2** | 2 | | | | | **100** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 30 | **47** | 20 | 19 | 2 | 2 | 4 | **78.8** |
| 8 | Засгийн газрын албан даалгавар | 1 | **2** | 2 | | | | | **100** |
| **Хэрэгжилтийн дүн** | | **93** | **182** | **101** | **53** | **4** | **3** | **21** | **86.5** |

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

Тайланг нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ

Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ